



Долоо хоног тутмын хэвлэл
2015 оны 07 дугаар сарын 03
№25 /886/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
хууль

1143

Монгол Улсын
хууль

1181

Монгол Улсын
Их Хурлын
тогтоол

1194

**Хууль тогтоомжийн тухай
/Шинэчилсэн найруулга/**

**Шүүх байгуулах тухай
/Шинэчилсэн найруулга/**

**Төрөөс тэтгэврийн
шинэчлэлийн талаар
баримтлах бодлого батлах
тухай**



ГАРЧИГ
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

289.	Хууль тогтоомжийн тухай /Шинэчилсэн найруулга/	1143
290.	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1174
291.	Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1175
292.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1176
293.	Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1176
294.	Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1177
295.	Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай	1177
296.	Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	1178
297.	Гаалийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай	1178
298.	Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай	1178
299.	Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1179
300.	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1181
301.	Шүүх байгуулах тухай /Шинэчилсэн найруулга/	1181
302.	Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1193
303.	Шүүх байгуулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	1194

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

304.	Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого батлах тухай	Дугаар 53 1194
------	---	-------------------



305.	Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 08 дугаар дүгнэлтийн тухай	Дугаар 55	1203
306.	Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 09 дүгээр дүгнэлтийн тухай	Дугаар 56	1203
307.	“Гацууртын ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл буцаах тухай	Дугаар 57	1204
308.	“Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай	Дугаар 58	1205
309.	Шүүгчийн орон тоо батлах тухай	Дугаар 59	1205
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ			
310.	Ц.Бямбажавыг албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 103	1213
311.	Д.Давааг албан тушаалд томилох тухай	Дугаар 104	1214
312.	Зарим хүмүүсийг анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 108	1214
313.	Зарим хүмүүсийг шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 109	1215
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ			
314.	Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2015 оны хэмжээг тогтоох тухай	Дугаар 183	1216
МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ			
315.	Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн холбогдох заалт Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай	Дугаар 05	1217



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 05 дугаар
сарын 29-ний өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилго

1.1.Энэ хуулийн зорилго нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр /цаашид “хууль тогтоомж” гэх/-ийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлэхэд оршино.

2 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

2.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1.“хууль санаачлагч” гэж Монгол Улсын Үндсэн хуулийн¹ Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан этгээдийг;

2.1.2.“хууль санаачлах эрх” гэж хууль санаачлагчаас тодорхой хууль гаргах тухай санал дэвшүүлж, мэргэжлийн түвшинд боловсруулах, боловсруулсан хуулийн төслийг хянаж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг;

2.1.3.“хуулийн төсөл” гэж хууль санаачлагчаас энэ хуульд заасан шаардлагыг ханган боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хуулийн төслийн эх бичвэрийг;

2.1.4.“Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл” гэж хууль санаачлагчаас энэ хуульд заасан шаардлагыг ханган боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх Улсын Их Хурлын тогтоолын төслийг.

¹ Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.



3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь хууль тогтоомжийг санаачлан боловсруулах, олон нийтийн оролцоог хангах, эрх зүйн дүгнэлт хийх, өргөн мэдүүлэх, батлагдсан хууль тогтоомжийг хэвлэн нийтлэх, олон нийтэд таниулах, түүний хэрэгжилтийг зохион байгуулах болон хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

4 дүгээр зүйл.Нийтлэг зарчим

4.1.Энэ хуулийг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан зарчмаас гадна дараах нийтлэг зарчмыг баримтална:

- 4.1.1.ил тод, нээлттэй байх;
- 4.1.2.олон нийтийн оролцоог хангах;
- 4.1.3.ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
- 4.1.4.судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХУУЛЬ ТОГТООМЖ САНААЧЛАХ, ТӨЛӨВЛӨХ

5 дугаар зүйл.Хууль санаачлах

5.1.Хууль санаачлагч тодорхой хууль гаргах тухай санал дэвшүүлэх тохиолдолд холбогдох хуулийн төслийг энэ хуульд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

5.2.Иргэн, хуулийн этгээд хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид уламжилна. Хууль санаачлагч уг саналыг үндэслэлтэй гэж үзвэл тухайн асуудлаар хууль санаачилж болно.

6 дугаар зүйл.Улсын Их Хурлын тогтоол санаачлах

6.1.Хууль санаачлагч Улсын Их Хурлын тогтоолыг санаачилж болно. Хуульд заасан тохиолдолд бусад байгууллага холбогдох саналаа хууль санаачлагчид уламжилна.

6.2.Улсын Их Хурлын дотоод зохион байгуулалт, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын үйл ажиллагааны тухай тогтоолыг холбогдох Байнгын хорооны түвшинд Улсын Их Хурлын гишүүд санаачилж болно.



6.3.Улсын Их Хурлын анхдугаар чуулганаар Улсын Их Хурлын дарга, дэд даргыг сонгох тухай Улсын Их Хурлын тогтоолд энэ хуулийн 6.1, 6.2 дахь хэсэг хамаарахгүй.

7 дугаар зүйл.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг төлөвлөх

7.1.Засгийн газар тухайн бүрэн эрхийнхээ хугацаанд санаачлах хууль тогтоомжийн талаар урьдчилан төлөвлөж, Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл /цаашид “Үндсэн чиглэл” гэх/-д тусгана.

7.2.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох байгууллагын саналыг авч, нэгтгэн судалсны үндсэн дээр Үндсэн чиглэлийн төслийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн боловсруулна.

7.3.Үндсэн чиглэлийн төсөлд санал өгөх байгууллага нь нийгмийн тухайн харилцааг зохицуулж байгаа хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг судалсны үндсэн дээр уг асуудлаар шинээр хууль гаргах, эсхүл хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагыг тодорхойлно.

7.4.Үндсэн чиглэлийн төслийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хэлэлцэн батална.

7.5.Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх хууль тогтоомжийн төслийн жагсаалт, дэс дарааллыг тогтооходоо Үндсэн чиглэлд тусгагдсан хууль тогтоомжийн төслийг тэргүүн ээлжид хэлэлцэх зарчим баримтална.

7.6.Үндсэн чиглэлд тусгагдаагүй боловч хууль тогтоомжоор зохицуулах зайлшгүй шаардлагатай гэж үзвэл Засгийн газар холбогдох хууль тогтоомжийн төслийг санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

8 дугаар зүйл.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын үе шат

8.1.Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:



8.1.1.энэ хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах;

8.1.2.энэ хуулийн 14, 15 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, батлах;

8.1.3.энэ хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн төслийг боловсруулах;

8.1.4.энэ хуулийн 17, 18 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог хийх;

8.1.5.эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлж, санал авах;

8.1.6.хууль тогтоомжийн төсөлд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагын саналыг авах;

8.1.7.хууль тогтоомжийн төсөлд эрх зүйн дүгнэлт хийх эрх бүхий этгээдээс санал, дүгнэлт авах;

8.1.8.хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;

8.1.9.энэ хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийг хангаж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

9 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг хариуцах

9.1.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг хууль санаачлагч хариуцан зохион байгуулна.

9.2.Засгийн газрын санаачлах хууль тогтоомжийн төслийг холбогдох төрийн захиргааны төв байгууллага Үндсэн чиглэлд заасны дагуу, эсхүл Засгийн газрын даалгавраар зохих хүрээ, салбарын асуудлаар хариуцан боловсруулна.

9.3.Хууль санаачлагч салбар хоорондын уялдааг хангах зорилгоор холбогдох байгууллагын удирдлагатай тохиролцож, тухайн асуудлыг хариуцсан мэргэжилтнийг хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажилд оролцуулж болно.



9.4.Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулахад шаардлагатай тооцоо, судалгаа, мэдээ, баримтыг холбогдох хуулийн этгээд, албан тушаалтнаас гаргуулан авах эрхтэй.

9.5.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах явцад холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллага, шинжээч, эрдэмтэн, иргэн, хуулийн этгээдээс санал авч, төсөл боловсруулахад харгалзан үзнэ.

10 дугаар зүйл.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах хэлбэр

10.1.Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг дараах хэлбэрээр зохион байгуулна:

10.1.1.хууль тогтоомжийн төслийг өөрөө боловсруулах;

10.1.2.холбогдох байгууллагын мэргэжилтнээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах;

10.1.3.иргэн, хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх.

11 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг санхүүжүүлэх

11.1.Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулахтай холбогдон гарах зардлыг өөрийн төсвөөс санхүүжүүлнэ.

11.2.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг хууль тогтоох үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх зорилгогүйгээр ашгийн бус байгууллага санхүүжүүлж болно.

12 дугаар зүйл.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг арга зүйн удирдлагаар хангах

12.1.Засгийн газар дараах аргачлалыг баталж, мөрдүүлнэ:

12.1.1.хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал;

12.1.2.хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал;

12.1.3.хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал;

12.1.4.хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал;



12.1.5.хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийх аргачлал;

12.1.6.хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал.

13 дугаар зүйл.Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах

13.1.Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг энэ хуулийн 12.1.2-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.

13.2.Энэ хуулийн 12.1.2-т заасан аргачлалаар дараах асуудлыг зохицуулна:

13.2.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэх эсэхийг судалж, дүгнэх;

13.2.2.тухайн асуудлыг хууль тогтоомжоор зохицуулах шаардлагатай эсэхийг тодорхойлох;

13.2.3.тухайн асуудлыг шийдвэрлэх зохицуулалтын хувилбаруудыг тодорхойлох;

13.2.4.зохицуулалтын хувилбарын эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах;

13.2.5.хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг урьдчилан тооцсоны үндсэн дээр тухайн асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй хувилбарыг тодорхойлох;

13.2.6.хууль тогтоомжийн зохицуулалт нь олон улсын эрх зүйн холбогдох зохицуулалт, бусад улсын адил төстэй хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа хийсэн байх.

14 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төсөл боловсруулах

14.1.Хууль санаачлагч хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсны үндсэн дээр үзэл баримтлалын төсөл боловсруулна.

14.2.Энэ хуулийн 14.1-д заасан үзэл баримтлалын төсөлд дараах асуудлыг тусгана:



14.2.1.хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага;

14.2.2.хууль тогтоомжийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ;

14.2.3.хууль тогтоомж батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал;

14.2.4.хууль тогтоомжийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал.

14.3.Энэ хуулийн 14.2.1-д заасан үндэслэл, шаардлагад тухайн хууль тогтоомжийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг тодорхой тайлбарлаж тусгана.

15 дугаар зүйл.Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалыг батлах

15.1.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн өөрийн санаачлах хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, батална.

15.2.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн санаачлах хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлж болно. Энэ тохиолдолд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн зөвлөмж гаргана.

15.3.Засгийн газрын санаачлах хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.

15.4.Хууль тогтоомжоор зохицуулах нийгмийн харилцаа нь Засгийн газрын хэд хэдэн гишүүний эрхлэх асуудлын хүрээнд хамаарч байвал хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагууд нь хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.

15.5.Төрийн захиргааны төв байгууллага санхүү, төсөв, татварын чиглэлээр боловсруулсан хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын



төслийг санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.

15.6.Олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг тухайн гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, гадаад хэргийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.

15.7.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах нийгмийн харилцааг зохицуулсан хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг дангаар батална:

15.7.1.төрийн байгуулалт, эрүү, иргэний зэрэг салбарын бус нийтлэг харилцаа;

15.7.2.Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар хуульд тусгайлан зааснаас бусад асуудал.

15.8.Төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг энэ хуулийн 15.3-15.6-д заасан төрийн захиргааны төв байгууллага 30 хоногийн дотор хянан үзэж, дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

15.8.1.төслийг дэмжиж хамтран батлах;

15.8.2.төслийг дахин боловсруулах санал гаргаж, буцаах;

15.8.3.тухайн харилцааг хуулиар зохицуулах шаардлагагүй тухай дүгнэлт гаргах.

15.9.Энэ хуулийн 15.8.2, 15.8.3-т заасны дагуу хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг хянасан талаарх санал, дүгнэлтэд үндэслэлийг тодорхой заана.

16 дугаар зүйл.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах

16.1.Хууль тогтоомжийн төслийг үзэл баримтлалд нь нийцүүлэн боловсруулна.

16.2.Хууль тогтоомжийн төслийг энэ хуулийн Дөрөвдүгээр бүлэг болон 12.1.1-д заасан аргачлалын дагуу боловсруулна.

16.3.Хууль тогтоомжийн төсөл боловсруулахдаа бусад хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт, тэдгээрийг дагаж гарах шийдвэрийн төслийг хамт боловсруулж, холбогдох тооцоо, судалгаа хийсэн байна.



16.4.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хууль тогтоомжийн төсөл боловсруулах талаар төрийн захиргааны төв байгууллага болон бусад байгууллагад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч болно.

17 дугаар зүйл.Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх

17.1.Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг энэ хуулийн 12.1.3-т заасан аргачлалын дагуу үнэлнэ.

17.2.Энэ хуулийн 12.1.3-т заасан аргачлалд дараах асуудлыг тусгана:

17.2.1.хууль тогтоомжийн төсөл, эсхүл түүний зарим зүйл, заалтын зохицуулалтын практикт хэрэгжих боломж, харилцан уялдаа зэргийг тооцож шинжилгээ хийх;

17.2.2.хууль тогтоомжийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах;

17.2.3.хууль тогтоомжийн төслийг батлан хэрэгжүүлснээр үүсэж болзошгүй, урьдчилан тооцоогүй үр дагаврыг тодорхойлох.

17.3.Хууль тогтоомжийн төслийг батлан хэрэгжүүлснээр гарах үр нөлөөг тооцсоны үндсэн дээр шаардлагатай бол тухайн хууль тогтоомжийн төсөл, эсхүл түүний зарим зүйл, заалтыг дахин боловсруулна.

18 дугаар зүйл.Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцох

18.1.Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.

18.2.Энэ хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах болон энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхэд энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалыг баримталж болно.

19 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн төсөлд эрх зүйн дүгнэлт хийх

19.1.Засгийн газрын санаачилсан хууль тогтоомжийн төсөл энэ хуульд заасан шаардлагыг хангасан эсэхэд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрх зүйн дүгнэлт хийнэ.



19.2.Хууль санаачлагчийн боловсруулсан хууль тогтоомжийн төсөл энэ хуульд заасан шаардлагыг хангасан эсэхэд Улсын Их Хурлын Тамгын газар эрх зүйн дүгнэлт хийнэ.

20 дугаар зүйл.Засгийн газрын санаачилсан хууль тогтоомжийн төсөлд санал авах, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх

20.1.Төрийн захиргааны төв байгууллагын боловсруулсан хууль тогтоомжийн төсөлд холбогдох төрийн захиргааны төв байгууллага 30 хоногийн дотор саналаа өгнө.

20.2.Энэ хуулийн 20.1-д заасан хугацаанд саналаа ирүүлээгүй бол тусгайлан өгөх саналгүй гэж үзнэ.

20.3.Төрийн захиргааны төв байгууллага боловсруулсан хууль тогтоомжийн төсөлдөө бусад төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох төрийн байгууллагын саналыг авч, үндэслэлтэй гэж үзвэл тухайн төсөлд тусгана. Төрийн захиргааны төв байгууллагын саналд тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гарын үсэг зурсан байна.

20.4.Төрийн захиргааны төв байгууллага боловсруулсан хууль тогтоомжийн төслөө Сайдын зөвлөлөөр хэлэлцүүлсний дараа холбогдох бусад баримт бичгийн хамт хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулахаар хүргүүлнэ. Хууль тогтоомжийн төсөл төсвийн зардал нэмэгдүүлэх, орлого бууруулах үр дагаврыг бий болгохоор бол санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулахаар хүргүүлнэ.

20.5.Хууль тогтоомжийн төсөл энэ хуульд заасан шаардлагыг хангаагүй бол хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага уг төслийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагад үндэслэл бүхий тайлбарын хамт буцаана.

20.6.Энэ хуулийн 20.5-д заасны дагуу хууль тогтоомжийн төслийг буцаасан тохиолдолд төрийн захиргааны төв байгууллага тухайн төслийг дахин боловсруулж, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулахаар хүргүүлнэ.

20.7.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Засгийн газрын санаачилсан хууль тогтоомжийн төсөл төсвийн зардал нэмэгдүүлэх, орлого бууруулах эсэхийг эцэслэн хянаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгоно.



20.8.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Засгийн газрын санаачилсан хууль тогтоомжийн төсөл энэ хуульд заасан шаардлагад нийцсэн эсэхийг эцэслэн хянаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгоно.

20.9.Гадаад хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгоно.

20.10.Энэ хуулийн 20.7-20.9-д заасан зөвшөөрлийг бичгээр үйлдэнэ.

20.11.Энэ хуулийн 20.10-т заасан зөвшөөрлийг авсны үндсэн дээр төрийн захиргааны төв байгууллага боловсруулсан хууль тогтоомжийн төслөө Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

21 дүгээр зүйл.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүний санаачилсан хууль тогтоомжийн төсөлд Засгийн газрын санал, дүгнэлтийг авах, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх

21.1.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн санаачилсан хууль тогтоомжийн төслөө санал, дүгнэлт авахаар Засгийн газарт хүргүүлнэ.

21.2.Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хууль тогтоомжийн төслийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор Засгийн газрын санал, дүгнэлтийн төслийг бэлтгүүлэхээр хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

21.3.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүний санаачилсан хууль тогтоомжийн төслийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор Засгийн газрын бусад гишүүн, холбогдох байгууллагад хүргүүлнэ.

21.4.Энэ хуулийн 21.3-т заасан байгууллага, албан тушаалтан нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүний санаачилсан хууль тогтоомжийн төсөлд өгөх саналыг тухайн хууль тогтоомжийн төслийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор бэлтгэж, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

21.5.Төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 21.4-т заасан хугацаанд саналаа ирүүлээгүй бол тусгайлан өгөх саналгүй гэж үзнэ.



21.6.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын бусад гишүүнээс ирүүлсэн саналыг Засгийн газрын санал, дүгнэлтийн төсөлд тусгахдаа дараах зарчмыг баримтална:

21.6.1.зарчмын шинжтэй саналуудыг нэг бүрчлэн томъёолох;

21.6.2.хэл зүй, найруулга, томъёоллын шинжтэй саналуудыг багцлах.

21.7.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 21.4-т заасан хугацаа өнгөрсөн өдрөөс хойш ажлын долоон өдрийн дотор Засгийн газрын санал, дүгнэлтийн төслийг бэлтгэж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

21.8.Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Засгийн газрын санал, дүгнэлтийн төслийг энэ хуулийн 21.7-д заасны дагуу хүлээн авсан өдрөөс хойш ажлын долоон өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

21.9.Энэ хуулийн 21.7-д заасан Засгийн газрын санал, дүгнэлтийн төсөлд дараах асуудлыг тусгана:

21.9.1.тухайн хууль тогтоомжийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Үндсэн чиглэлд нийцэж байгаа эсэх;

21.9.2.тухайн хууль тогтоомжийн төсөл бусад хууль тогтоомжтой уялдсан эсэх;

21.9.3.тухайн хууль тогтоомжийн төсөл энэ хуульд заасан шаардлагыг хангасан эсэх.

21.10.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүний санаачилсан хууль тогтоомжийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд² заасан төсвийн тусгай шаардлага, Төсвийн тухай хуульд³ заасан төсвийн бусад шаардлага, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг хангаж байгаа эсэх талаарх Засгийн газрын санал, дүгнэлтийн төслийг бэлтгэж, энэ хуулийн 21.4-т заасан хугацаанд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.

² Төсвийн тогтвортой байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2010 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

³ Төсвийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 03 дугаарт нийтлэгдсэн.



21.11.Засгийн газар санал, дүгнэлтээ ажлын 30 өдрийн дотор хууль санаачлагчид хүргүүлнэ. Шаардлагатай тохиолдолд хууль санаачлагчтай тохиролцон түүний бичгээр өгсөн зөвшөөрлийг үндэслэн уг хугацааг сунгаж болно.

21.12.Засгийн газар энэ хуулийн 21.11-д заасан хугацаанд саналаа ирүүлээгүй бол тусгайлан өгөх саналгүй гэж үзнэ.

21.13.Засгийн газар энэ хуулийн 21.1-д заасан хууль тогтоомжийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль болон эрх зүйн бодлогод нийцээгүй, энэ хуульд заасан шаардлагыг хангаагүй гэсэн дүгнэлт гаргасан тохиолдолд уг дүгнэлтийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд заавал танилцуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТӨРӨЛ, БҮТЭЦ, ХЭЛБЭР, ЭХ БИЧВЭРТ ТАВИХ ШААРДЛАГА

22 дугаар зүйл.Хуулийн төслийн төрөл

22.1.Хуулийн төсөл дараах төрөлтэй байна:

- 22.1.1.анхдагч хуулийн төсөл;
- 22.1.2.хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл;
- 22.1.3.хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;
- 22.1.4.багц хуулийн төсөл.

23 дугаар зүйл.Анхдагч хуулийн төсөл

23.1.Хууль санаачлагч нийгмийн харилцааны төлөв байдал, тулгамдсан асуудлыг судалсны үндсэн дээр шинээр үүссэн харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай, эсхүл тухайн нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзвэл анхдагч хуулийн төсөл боловсруулна.

24 дүгээр зүйл.Хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл

24.1.Нийгмийн харилцааны тулгамдсан асуудлыг харгалзан тухайн хуульд нэмэлт оруулах, хуулийн зарим зүйл, заалтыг өөрчлөн найруулах, хуулийг бүхэлд нь, эсхүл тодорхой зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох асуудлаар хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулна.

24.2.Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хэд



хэдэн хуульд нэгэн зэрэг өөрчлөлт оруулах хуулийн төслийг Засгийн газар санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно. Энэ тохиолдолд өөрчлөлт оруулж байгаа хууль тус бүрд үзэл баримтлалыг тодорхойлох шаардлагагүй.

24.3.Хуулийн өөрчлөлтийг хуулийн анхдагч эх бичвэрт оруулна.

24.4.Тухайн хуульд нэмэлт оруулах бол “нэмэлт оруулах тухай”, өөрчлөлт оруулах бол “өөрчлөлт оруулах тухай”, нэмэлт, өөрчлөлт аль алийг нь оруулах бол “нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, хууль, хуулийн зүйл, заалтыг хүчингүй болгох бол “хүчингүй болсонд тооцох тухай” гэж хуулийн төслийг ялгавартай нэрлэнэ.

24.5.Хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл нь дараах төрөлд хуваагдана:

24.5.1.хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;

24.5.2.хуульд нэмэлт оруулах тухай;

24.5.3.хуульд өөрчлөлт оруулах тухай;

24.5.4.хууль, хуулийн зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай.

24.6.Хуульд оруулах өөрчлөлтийг зөвхөн нэг хуульд хамааруулж хийх бөгөөд өөрчлөлт орж байгаа хуулийн нэр, зүйл, хэсэг, заалтын дугаарыг тодорхой бичнэ.

24.7.Хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөлд зүйлийн гарчиг тавилгүйгээр зүйлийн агуулгыг дугаарын хойноос шууд бичнэ.

24.8.Хуулийн нэг зүйлд хэд хэдэн өөрчлөлт оруулж байгаа бол өөрчлөлт тус бүрийг бие даасан заалт болгон тэмдэглэнэ.

24.9.Өөрчлөлт оруулж байгаа зүйл, хэсэг, заалтын зарим нэр томъёо, үг хэллэгийг өөрчилсөн буюу хассанаар түүний утга агуулга нэг мөр ойлгогдохооргүй байвал түүнийг өөрчлөн найруулна.

24.10.Хүчингүй болсонд тооцож байгаа хуулийн төслийн заалтад тухайн хуулийн хүчингүй болсонд тооцох бүх зүйл, хэсэг, заалтыг тусгана.

24.11.Хэрэв хуулийн төсөлтэй холбогдон хэд хэдэн хуульд нэр томъёоны өөрчлөлт оруулах бол хууль бүрд оруулах өөрчлөлтийг тусгасан нэг хуулийн төсөл боловсруулж болно.



25 дугаар зүйл.Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

25.1.Дараах тохиолдолд хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулна:

25.1.1.өмнө нь тухайн хуулийн нийт заалтын 50-иас дээш хувьд нь нэмэлт, өөрчлөлт орсон бол;

25.1.2.хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны улмаас хуулийн бүтэц, уялдаа алдагдахад хүрэх, эсхүл тухайн хуулийн нийт заалтын 50-иас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орох бол;

25.1.3.хуулийн үзэл баримтлалыг бүхэлд нь өөрчлөхөд хүргэсэн нэмэлт, өөрчлөлт орох бол;

25.1.4.тухайн хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцааны төлөв байдал, агуулгад ихээхэн өөрчлөлт гарч, түүнтэй уялдуулан хуулийг шинэчлэн батлах шаардлагатай болсон.

25.2.Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахдаа анхдагч хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хамтад нь боловсруулна.

26 дугаар зүйл.Багц хуулийн төсөл

26.1.Засгийн газар тодорхой салбарын хоорондоо уялдаатай хэд хэдэн хуулийн төслийг нэгэн зэрэг хамтад нь хэлэлцүүлэхээр багц хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлж болно. Энэ тохиолдолд хууль тус бүрийн үзэл баримтлалыг тодорхойлно.

27 дугаар зүйл.Хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт

27.1.Хуулийг дагаж мөрдөх журмаар дараах асуудлыг зохицуулна:

27.1.1.хууль бүхэлдээ, эсхүл хуулийн тодорхой анги, хэсэг, бүлэг, зүйл, заалт хүчин төгөлдөр үйлчилж эхлэх нөхцөл;

27.1.2.хууль хэрэгжүүлэхтэй холбоотой зохион байгуулалт, шилжилтийн үе шатны бэлтгэлийг хангах, шинэ бүтэц, ажлыг гүйцэтгэх нөхцөл;

27.1.3.өмнө үйлчилж байсан хууль, эрх зүйн зохицуулалтын дагуу үүссэн харилцаа, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүргийг шинэ хуулийн дагуу хэрхэн хамгаалах, хүлээн зөвшөөрөх,



баталгаажуулах, өөрчлөх, хүчингүй болсонд тооцох болон сөрөг үр дагаврыг арилгах нөхцөл, арга зам, хариуцлагыг зохицуулах хэлбэр;

27.1.4.хууль үйлчилж эхэлсэнтэй холбоотой аливаа зардал, нөхөх олговор, хохирлыг нөхөн төлөх нөхцөл;

27.1.5.өмнөх хууль, эрх зүйн зохицуулалт, тэдгээрийн зарим хэсэг хүчин төгөлдөр үйлчлэх тодорхой нөхцөл, тохиолдол;

27.1.6.хууль буцаж үйлчлэх онцгой тохиолдол.

28 дугаар зүйл.Хуулийн төслийн бүтэц, хэлбэр

28.1.Хуулийн төсөл дараах бүтэцтэй байна:

28.1.1.хуулийн төслийн гарчиг;

28.1.2.хуулийн төслийн бүтцийн үндсэн нэгж болох зүйл;

28.1.3.зүйлийн доторх хэсэг;

28.1.4.хэсгийн доторх заалт;

28.1.5.заалтын доторх дэд заалт;

28.1.6.шаардлагатай бол бүлэг, дэд бүлэг, хэсэг, дэд хэсэг,

анги.

28.2.Хуулийн төслийн бүтэц дараах шаардлагыг хангасан байна:

28.2.1.зүйл нь хоорондоо уялдаа холбоо, дэс дараалал бүхий, агуулгыг товч илэрхийлсэн гарчиг, нэгдсэн дугаартай байх;

28.2.2.бие даасан санаа бүрийг зүйлд тусгах;

28.2.3.бие даасан санаа нь хэд хэдэн өгүүлбэрээр илэрхийлэгдэж байвал зүйлийг хэсэгт хуваах;

28.2.4.заалт нь аль болох нэг өгүүлбэрээс бүрдсэн байх;

28.2.5.зүйлүүдийг сэдвээр нь бүлэглэж, бүлгийг хэсэг, ангид нэгтгэж болно.

28.3.Хуулийн төслийн бүтцийг дараах хэлбэрт оруулж байрлуулна:

28.3.1.хуулийн төслийн гарчиг;

28.3.2.нийтлэг хэм хэмжээ тогтоож байгаа зүйлийг нэгтгэсэн “ерөнхий анги”, эсхүл “нийтлэг үндэслэл” гэсэн бүлэг, хэсэг;

28.3.3.нэр томъёоны тайлбар;

28.3.4.тусгайлсан хэм хэмжээ тогтоож байгаа зүйлийг



нэгтгэсэн тусгай “анги”, эсхүл агуулгаар нь бүлэг, хэсэг болгосон эрх зүйн хэм хэмжээ;

28.3.5.иргэн, хуулийн этгээдээс үйл ажиллагаа явуулах журам, тэдгээрийн эрх, үүрэг;

28.3.6.онцгойлон үзэх нөхцөл байдал;

28.3.7.хариуцлага тогтоож байгаа хэм хэмжээ;

28.3.8.хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт;

28.3.9.шаардлагатай бол хууль хүчин төгөлдөр болох тухай хэм хэмжээ;

28.3.10.бусад зүйл.

28.4.Хуулийн төслийн гарчиг дараах зүйлээс бүрдэнэ:

28.4.1.“Монгол Улсын хууль” гэсэн толгой;

28.4.2.хуулийг баталсан он, сар, өдөр /араб тоогоор бичнэ/;

28.4.3.хуулийг баталсан газар /хот/-ын нэр;

28.4.4.агуулгыг товч, тодорхой илэрхийлсэн хуулийн нэр.

28.5.Энэ хуулийн 28.4.4-т заасан хуулийн нэрийг дан том үсгээр бичих бөгөөд дараах төрөлтэй байна:

28.5.1.тухайлсан нь: “... тухай” гэсэн үгээр төгсгөнө. /АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ, МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ г.м/

28.5.2.оноосон нь: “...-ийн хууль” гэдэг үгээр төгсгөнө. /ИРГЭНИЙ ХУУЛЬ, АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ г.м/

28.6.Хуулийн төслийн бүтцийн хэсгийг дараах байдлаар дугаарлана:

28.6.1.анги, хэсгийг ром тоогоор, эсхүл бичгээр;

28.6.2.бүлгийг бичгээр;

28.6.3.зүйлийг араб тоогоор, ард нь “дүгээр”, эсхүл “дугаар” зүйл гэж бичгээр /1 дүгээр зүйл. г.м/;

28.6.4.зүйлийн доторх хэсгийг баруун талдаа цэгтэй араб тоогоор /1.1. г.м./;

28.6.5.зүйлийн доторх хэсгийн доторх заалтыг баруун талдаа цэгтэй араб тоогоор /1.1.1. г.м/;



28.6.6.заалтын доторх дэд заалтыг үсгээр /1.1.1.а. г.м/.

28.7.Зохицуулах харилцааны онцлогоос хамаарч шаардлагатай тохиолдолд хуулийн төслийн бүтцийн хэсгийг дараах байдлаар дугаарлаж болно:

28.7.1.зүйлийг дугаарлахдаа зүйлийн дугаарын өмнө нь баруун талдаа цэгтэй тухайн бүлгийн дугаарыг араб тоогоор бичиж, ард нь “дүгээр”, эсхүл “дугаар” гэж бичгээр /1.1. дүгээр зүйл г.м/;

28.7.2.хэсгийг баруун талдаа цэгтэй араб тоогоор /1. г.м./;

28.7.3.хэсгийн доторх заалтыг баруун талдаа цэгтэй араб тоогоор /1.1. г.м/;

28.7.4.заалтын доторх дэд заалтыг үсгээр /1.1.а. г.м/.

28.8.Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн заалтыг дараах дарааллаар байрлуулна:

28.8.1.хуульд нэмэлт оруулах;

28.8.2.хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг өөрчлөн найруулах;

28.8.3.хуулийн зарим нэр томъёо, үг, өгүүлбэрийг өөрчлөх;

28.8.4.хуулийн зарим үг, өгүүлбэрийг хасах;

28.8.5.зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох;

28.8.6.шаардлагатай бол хуулийг дагаж мөрдөх хугацаа.

28.9.Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл доторх заалтыг баруун талдаа хаалт бүхий араб тоогоор дугаарлана /1/ г.м/.

28.10.Хуульд шинээр нэмэгдэх зүйл нь анхдагч эх бичвэрийн тухайн зүйл заалтаас салшгүй утга агуулгатай бол дугаарыг тэмдэглэхдээ баруун дээд өнцөгт нь жижиг араб тоогоор дугаарлана /52¹ дүгээр зүйл г.м/.

29 дүгээр зүйл.Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага

29.1.Хуулийн төслийн агуулга дараах нийтлэг шаардлага хангасан байна:

29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;



29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;

29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;

29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;

29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;

29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;

29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;

29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;

29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;

29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;

29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.

30 дугаар зүйл.Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага

30.1.Хуулийн төслийн хэл зүй, найруулга дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:



30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;

30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;

30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;

30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;

30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.

30.2.Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн дэргэд хууль зүйн нэр томъёог шинжлэх ухааны үндэслэлтэй оноон тогтоох, жигдлэн хэвшүүлэх, нэр томъёотой холбогдсон асуудлаар зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий Хууль зүйн хэлний салбар зөвлөл ажиллана.

30.3.Хууль зүйн хэлний салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хууль зүйн болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

30.4.Хуулийн төсөлд дараах тохиолдолд нэр томъёоны тайлбар хийнэ:

30.4.1.нэр томъёо нь олон утгатай бол;

30.4.2.нэр томъёо нь өргөн утгатай бөгөөд түүнийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай бол;

30.4.3.шинээр бий болсон ойлголт буюу нэр томъёо нь нийтэд ойлгомжгүй бол.

30.5.Хуулийн төсөлд дараах тохиолдолд гадаад хэлний нэр томъёо хэрэглэж болно:

30.5.1.үг нэр томъёог оноосон нэр монгол хэлэнд байхгүй бол;

30.5.2.үг нэр томъёог олон улсын хэмжээнд нийтлэг хэрэглэж хэвшсэн бол;

30.5.3.үг нэр томъёог Монгол Улсын олон улсын гэрээнд хэрэглэж байгаа бол.

30.6.Нэр томъёо нь нэг утга агуулгаар нийт хуулийн хэмжээнд хэрэглэгдэх бол түүний тодорхойлолтыг уг хуулийн “Нийтлэг үндэслэл”



гэсэн бүлэгт оруулан заана. Хуулийн төсөлд тодорхойлолт өгсөн хэд хэдэн нэр томьёо байгаа бол тэдгээрийг “Хуулийн нэр томьёоны тодорхойлолт” гэсэн гарчигтай зүйлд нэгтгэнэ.

30.7.Нэр томьёо нь тодорхой утга агуулгаар зөвхөн зүйл, хэсэг, заалтын хүрээнд хэрэглэгдэх бол түүний тодорхойлолтыг уг зүйл, хэсэг, заалтын дотор байрлуулж, түүний үйлчлэх хүрээг тодорхой заана.

31 дүгээр зүйл.Хуулийн төсөлд товчлол хэрэглэх

31.1.Хуулийн төсөлд олон дахин давтагдаж байгаа нэг ойлголт, нэр томьёог хэд хэдэн үгээр илэрхийлэх тохиолдолд тэдгээрийг цөөн үгээр хэрэглэх зорилгоор товчлол хэрэглэнэ.

31.2.Дараах тохиолдолд товчлол хэрэглэхгүй:

31.2.1.хуулийн нэр, бүлэг, зүйлийн гарчигт;

31.2.2.тухайн үг олон удаа давтагдаагүй бол;

31.2.3.бусад хуульд хэрэглэсэн нэр томьёотой андуурахуйц байгаа бол.

32 дугаар зүйл.Хуулийн төсөлд эшлэл хэрэглэх

32.1.Хуулийн давхардал, зөрчил гарахаас сэргийлэх, ойлгож хэрэглэхэд хялбар болгох зорилгоор өөр хуульд байгаа, эсхүл тухайн хуульд нэгэнт туссан асуудлыг дахин дурдах бол эшлэл хэрэглэнэ.

32.2.Хуульд бусад хуулиас эшлэл хийхдээ тухайн заалтыг эх бичвэрээр нь хуулбарлахыг хориглоно.

33 дугаар зүйл.Хуулийн төслийн танилцуулга

33.1.Хууль санаачлагч хуулийн төслийн танилцуулга бэлтгэнэ.

33.2.Хуулийн төслийн танилцуулгад дараах мэдээллийг тусгана:

33.2.1.хуулийн төсөл боловсруулсан зорилго, ач холбогдол;

33.2.2.тухайн харилцааг урьд нь хууль, эрх зүйн бусад актаар зохицуулж ирсэн байдал;

33.2.3.хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан хууль санаачлагчаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;



33.2.4.хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн дүн;
33.2.5.гадаад орны туршлага, бусад судалгаа, шинжилгээний
тайлангийн дүгнэлт.

34 дүгээр зүйл.Олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төсөлд тавих нэмэлт шаардлага

34.1.Олон талт олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн
төсөлд тухайн гэрээний хянан баталгаажуулсан монгол хэлээрх орчуулгыг
хавсаргана.

34.2.Олон талт олон улсын гэрээний орчуулгыг тухайн гэрээгээр
зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
хариуцан гүйцэтгэж, гадаад хэргийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн
төрийн захиргааны төв байгууллага эрхлэх асуудлын хүрээнд уг орчуулгыг
хянан баталгаажуулна.

34.3.Хоёр талт олон улсын гэрээг талууд тохиролцсоны үндсэн
дээр гадаад улсын хэлээр үйлдсэн бол тухайн гэрээг соёрхон батлах тухай
хуулийн төсөлд энэ хуулийн 34.1, 34.2-т заасан шаардлага нэгэн адил
үйлчилнэ.

34.4.Гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон
улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээл, тусламжийн талаарх
олон улсын гэрээг орчуулах, орчуулгыг хянан баталгаажуулах үүргийг
тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүлээнэ.

34.5.Олон улсын гэрээг соёрхон баталснаар Монгол Улсын хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хууль шинээр батлах шаардлагатай
тохиолдолд тухайн хуулийн төслийг хамт боловсруулна.

ТАВДУГААР БҮЛЭГ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, ӨРГӨН МЭДҮҮЛЭХ

35 дугаар зүйл.Улсын Их Хурлын тогтоолын төслийн эх бичвэрт тавих шаардлага

35.1.Монгол Улсын Их Хурлын тогтоол /цаашид “Тогтоол” гэх/-ын
төсөл дараах шаардлагыг хангасан байна:

35.1.1.Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн, бусад хууль
болон Монгол Улсын олон улсын гэрээний заалттай уялдсан байх;



- 35.1.2.хуулийн заалтыг давтахгүй байх;
- 35.1.3.хариуцлагын хэм хэмжээ заахгүй байх.

36 дугаар зүйл.Тогтоолын төслийн бүтэц

36.1.Тогтоолын төсөл дараах бүтэцтэй байна:

- 36.1.1.тогтоолын төслийн гарчиг;
- 36.1.2.шаардлагатай бол тэмдэглэх хэсэг;
- 36.1.3.тогтоох хэсэг;
- 36.1.4.шаардлагатай бол урьд гаргасан шийдвэрийг хүчингүй болсонд тооцох тухай хэсэг;
- 36.1.5.шаардлагатай бол тогтоол хүчин төгөлдөр болох хугацаа.

36.2.Тогтоолын төслийн гарчиг дараах хэсгээс бүрдэнэ:

- 36.2.1.“Монгол Улсын Их Хурлын тогтоол” гэсэн толгой;
- 36.2.2.баталсан он, сар, өдөр /араб тоогоор бичнэ/;
- 36.2.3.тогтоол баталсан газар /хот/-ын нэр;
- 36.2.4.тогтоолын нэр. Тогтоолын нэр нь “... тухай” гэж төгсөнө.

36.3.Тогтоолын төслийн тэмдэглэх хэсэгт уг тогтоол гарах болсон үндэслэл, шаардлага, эсхүл хуулийн заалтыг үндэслэсэн байна.

36.4.Тогтоолын төслийн тогтоох хэсэгт уг тогтоолоор шийдвэрлэх асуудлыг энгийн, ойлгомжтой байдлаар томъёолж бичнэ.

36.5.Тогтоолын төслийн бүтцийн үндсэн нэгж нь заалт байх бөгөөд шаардлагатай тохиолдолд түүнийг дэд заалтад хувааж болно.

36.6.Тогтоол хавсралттай байж болох бөгөөд энэ тухай заалтыг “... -ыг хавсралтаар баталсугай.”, эсхүл “... -ыг 1, 2, 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай” гэж томъёолно.

36.7.Тогтоолын хавсралтын эхний хуудасны баруун дээд буланд “Монгол Улсын Их Хурлын ... оны ... дугаар тогтоолын хавсралт”, эсхүл “Монгол Улсын Их Хурлын ... оны ... дугаар тогтоолын ... дугаар хавсралт” гэж заана.

36.8.Тогтоолын төслийн заалтыг дараах байдлаар дугаарлана:



36.8.1.заалтыг баруун талдаа цэгтэй араб тоогоор /1. гм/;
36.8.2.заалтын доторх дэд заалтыг баруун талдаа хаалт бүхий араб тоогоор /1/гм/.

37 дугаар зүйл.Тогтоолын төслийг өргөн мэдүүлэх

37.1.Хууль санаачлагч тогтоолын төслөө энэ хуулийн 41.1-д заасан журмын дагуу өргөн мэдүүлнэ.

37.2.Тогтоолын төсөлд энэ хуулийн 40.1-д заасан баримт бичгийг хавсаргасан байна.

37.3.Тогтоолын төсөлд хавсаргах баримт бичиг нь албан хэрэг хөтлөлтийн нийтлэг шаардлагыг хангасан байна.

37.4.Энэ хуулийн 37.1, 37.2 дахь хэсэг нь энэ хуулийн 6.2, 6.3-т хамаарахгүй.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙГ ОЛОН НИЙТЭЭР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ, САНАЛ АВАХ

38 дугаар зүйл.Хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулах

38.1.Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс өмнө олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох материалыг баримтжуулан хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрт хавсаргана.

38.2.Хууль санаачлагч албан ёсны цахим хуудсандаа хууль тогтоомжийн төсөл, түүний үр нөлөөний үнэлгээний тайлан болон үзэл баримтлалыг байршуулж, хууль тогтоомжийн төсөлд санал өгөх хугацааг тодорхой заана.

38.3.Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 38.2-т заасан хугацаа 30-аас доошгүй хоног байна. Энэ хугацаанд иргэн, хуулийн этгээд саналаа бичгээр өгөх бөгөөд холбогдох этгээд гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

38.4.Хууль санаачлагч энэ хуулийн 38.3-т заасны дагуу ирүүлсэн саналыг харгалзан үзнэ.

38.5.Олон нийтийн хэлэлцүүлгийг дараах хэлбэрээр явуулна:



- 38.5.1.бичгээр санал авах;
- 38.5.2.уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах;
- 38.5.3.санал асуулга явуулах;
- 38.5.4.олон нийтийн цахим сүлжээгээр хэлэлцүүлэг явуулах;
- 38.5.5.бусад хэлбэр.

38.6.Хууль санаачлагч олон нийтийн хэлэлцүүлгийн хугацаа дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор хуулийн төсөлд тусгасан болон тусгаагүй саналын товъёгийг бэлтгэн албан ёсны цахим хуудсандаа байршуулна.

38.7.Хууль санаачлагчийн боловсруулж байгаа хууль тогтоомжийн төслийн үндэсний аюулгүй байдлын үүднээс хуулиар нууцад хамааруулсан асуудалтай холбоотой хэсгээр олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахгүй.

39 дүгээр зүйл.Төрийн байгууллагаас санал авах

39.1.Хууль санаачлагч санаачилж байгаа хууль тогтоомжийн төсөлдөө түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэг бүхий холбогдох бусад байгууллагаас санал авна.

39.2.Төрийн захиргааны төв байгууллага хууль тогтоомжийн төсөлд харьяа болон холбогдох мэргэжлийн байгууллагын саналыг авч нэгтгэн хууль санаачлагчид хүргүүлж болно.

39.3.Засгийн газрын санаачилсан хууль тогтоомжийн төсөлд тусгасан асуудал нь Улсын Их Хурлаас байгуулдаг төрийн байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах бол тухайн байгууллагаас санал авна.

39.4.Энэ хуулийн 39.1, 39.3-т заасан саналыг бичгээр үйлдэнэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ ӨРГӨН МЭДҮҮЛЭХ

40 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэр

40.1.Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төсөлд дараах баримт бичгийг хавсаргана:

40.1.1.хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлэх тухай хууль санаачлагчийн албан бичиг;

40.1.2.хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, судалгааны тайлан;



40.1.3.дагалдаж өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн төсөл;

40.1.4.олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төсөлд энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасан журмын дагуу хянан баталгаажуулсан олон улсын гэрээний монгол хэлээрх орчуулга;

40.1.5.хууль тогтоомжийн төсөл батлагдсан тохиолдолд түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо, авах арга хэмжээний санал;

40.1.6.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүний өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төслийн тухайд Засгийн газрын санал, дүгнэлт;

40.1.7.Засгийн газрын өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төслийн тухайд энэ хуулийн 20.7-20.9-д заасны дагуу санхүү, төсвийн, гадаад хэргийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бичгээр өгсөн зөвшөөрөл;

40.1.8.энэ хуулийн 15.2-т заасны дагуу авсан хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвлөмж;

40.1.9.энэ хуулийн 40.1.1-40.1.8-д заасан баримт бичгийн цахим хувь;

40.1.10.энэ хуулийн 38.6-д заасан саналын товъёг

40.2.Энэ хуулийн 40.1-д заасан баримт бичиг нь албан хэрэг хөтлөлтийн нийтлэг шаардлагыг хангасан байна.

40.3.Хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийн цахим хувийг үйлдэх, баталгаажуулах, хүлээлцэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

41 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх

41.1.Хууль санаачлагч энэ хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийг хангаж, өргөн мэдүүлэх тухай албан бичгийг Улсын Их Хурлын Тамгын газарт хүргүүлнэ.

41.2.Улсын Их Хурлын Тамгын газар хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр ирүүлсэн хууль тогтоомжийн төсөлд энэ хуулийн 41.3-т заасны дагуу эрх зүйн дүгнэлт гаргана.



41.3.Улсын Их Хурлын Тамгын газар хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөлд ажлын таван өдөр, анхдагч хуулийн төсөл болон хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ажлын 10 өдрийн дотор эрх зүйн дүгнэлт гаргана.

41.4.Улсын Их Хурлын Тамгын газар хууль тогтоомжийн төсөл энэ хуульд заасан шаардлагыг хангасан гэсэн эрх зүйн дүгнэлт гаргасан бол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга энэ тухай Улсын Их Хурлын даргад танилцуулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр товловсон хугацааг хууль санаачлагчид албан бичгээр мэдэгдэнэ.

41.5.Улсын Их Хурлын Тамгын газар хууль тогтоомжийн төсөл энэ хуульд заасан шаардлага хангасан гэсэн дүгнэлт гаргасан бол хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлнэ.

41.6.Улсын Их Хурлын Тамгын газар хууль тогтоомжийн төсөл энэ хуульд заасан шаардлагыг хангаагүй гэсэн дүгнэлт гаргасан бол уг дүгнэлтийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд танилцуулна.

41.7.Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо энэ хуулийн 41.6-д заасан дүгнэлтийг хэлэлцээд үндэслэлтэй гэж үзсэн бол хууль тогтоомжийн төслийг энэ хуульд заасан шаардлага хангуулахаар хууль санаачлагчид хүргүүлнэ.

41.8.Энэ хуулийн 41.2, 41.3 дахь хэсэг нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн⁴ 16¹ дүгээр зүйлд заасан тохиолдолд хамаарахгүй.

НАЙМДУГААР БҮЛЭГ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН САН, ХЭВЛЭН НИЙТЛЭХ,
ОЛОН НИЙТЭД ХҮРГЭХ, ТАНИУЛАХ

42 дугаар зүйл.Хууль тогтоомжийн албан ёсны эх

42.1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу ёсчилсон Улсын Их Хурлын Тамгын газарт хадгалах хууль тогтоомжийн хувийг албан ёсны эх гэнэ.

⁴ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2007 оны 39 дугаарт нийтлэгдсэн.



42.2.Хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэр, хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хурлын Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх үе шатанд бүрдүүлсэн баримт бичгийг байнга хадгална.

42.3.Хууль тогтоомжийн архивын нэгж бүрдүүлэх журмыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга батална.

43 дугаар зүйл.Хууль тогтоомжийг хэвлэн нийтлэх

43.1.Хууль тогтоомжийг Улсын Их Хурлын Тамгын газар “Хууль тогтоомжийн эмхэтгэл”-д хэвлэн нийтэлнэ.

43.2.Монгол Улсын олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийг соёрхон баталсан гэрээний хамт “Хууль тогтоомжийн эмхэтгэл”-д нийтэлнэ.

43.3.“Хууль тогтоомжийн эмхэтгэл”-д нийтэлсэн хууль тогтоомж албан ёсны эхтэйгээ зөрчилдсэн тохиолдолд албан ёсны эхийг баримтална.

44 дүгээр зүйл.Хууль тогтоомжийг хүргэх

44.1.Улсын Их Хурлын Тамгын газар хууль тогтоомжийн албан ёсны эхээс хуулбарласан хувийг холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулна.

44.2.Хууль тогтоомжийн албан ёсны эхээс хуулбарлан хүргүүлсэн хувийг хүлээж авсан төрийн байгууллага хууль тогтоомжийн санг бүрдүүлнэ.

44.3.Энэ хуулийн 44.2-т заасан хууль тогтоомжийн сан бүрдүүлэх, системчлэн ангилж, хууль тогтоомжийн хувийн хэрэг хөтлөх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

45 дугаар зүйл.Хууль тогтоомжийн сан бүрдүүлэх

45.1.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэдээлэл, лавлагаа өгөх зорилгоор Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомжийн нэгдсэн санг цаасан болон цахим хэлбэрээр бүрдүүлэх, хууль тогтоомжийг системчлэх ажлыг хариуцан зохион байгуулна.

45.2.Энэ хуулийн 45.1-д заасан санд Монгол Улсын олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийг соёрхон баталсан тухайн гэрээний хамт оруулна.



45.3.Хууль тогтоомжийн цахим санг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх зүйн мэдээллийн албан ёсны цахим хуудсанд байршуулна.

46 дугаар зүйл.Хууль тогтоомжийг олон нийтэд таниулах

46.1.Хууль тогтоомжийг олон нийтэд таниулах ажлыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо Улсын Их Хурлын Тамгын газартай хамтран зохион байгуулж болно.

46.2.Ерөнхийлөгчөөс санаачилсан хууль тогтоомжийг олон нийтэд таниулах ажлыг Ерөнхийлөгчийн Тамгын газар зохион байгуулж болно.

46.3.Засгийн газар, холбогдох төрийн захиргааны төв байгууллага, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга хууль тогтоомжийг өөрийн бүрэн эрх, чиг үүргийн дагуу харьяалах салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ

47 дугаар зүйл.Хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах нийтлэг арга хэмжээ

47.1.Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийг хүлээн авсан даруйд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хяналтын хувийн хэрэг нээж, харьяалах хүрээний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.

48 дугаар зүйл.Хуулиар тусгайлан эрх олгосны дагуу нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон акт гаргах

48.1.Хуульд тусгайлан зааж эрх олгосноос бусад тохиолдолд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн акт гаргахыг хориглоно.

48.2.Хуульд нийцээгүй, эсхүл хуулиар олгосон эрхийг хэтрүүлэн гаргасан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг дагаж мөрдөхгүй.

48.3.Хуульд өөрөөр заагаагүй бол нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн акт гаргах эрх хуулиар олгосон этгээд уг эрхээ бусдад шилжүүлэхийг хориглоно.



**АРАВДУГААР БҮЛЭГ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

**49 дүгээр зүйл. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт
шинжилгээ, үнэлгээ хийх нэгж**

49.1. Улсын Их Хурал, Засгийн газар хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх байнгын тогтолцоог бүрдүүлж, холбогдох бүтцийн нэгжийг ажиллуулна.

49.2. Улсын Их Хурлаас хийх хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газар хамтран хэрэгжүүлнэ.

49.3. Засгийн газраас хийх хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээг холбогдох төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

49.4. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хөндлөнгийн байгууллагаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэх буюу хамтарч болно.

49.5. Улсын Их Хурал, Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний бүтцийн нэгж нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн эерэг, сөрөг үр дагаврын талаарх хяналт шинжилгээний дүнг хууль санаачлагчид тогтмол мэдээлнэ.

49.6. Энэ хуулийн 49.5-д заасан хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээний дүнд үндэслэн хууль тогтоомжийн зорилгын түвшин хангалтгүй, хууль тогтоомжийн үзэл баримтлалд заасан үр дүнд хүрч чадахгүй тохиолдолд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийнэ.

49.7. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг тухайн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.

49.8. Хууль тогтоомжийн зохицуулах харилцааны онцлог, асуудлаас хамааран хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үр дагаврын үнэлгээ хийхдээ хууль тогтоомжийг бүтнээр нь, эсхүл зарим зүйл, заалтыг сонгож болно.



50 дугаар зүйл.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ

50.1.Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээг дараах чиглэлээр хийнэ:

50.1.1.хууль тогтоомжийн зорилгыг хангаж байгаа түвшинг тодорхойлох;

50.1.2.хууль тогтоомжийн үзэл баримтлалд тодорхойлсон үр дүнд хүрэх байдлыг тогтоох.

50.2.Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийх хяналт шинжилгээг энэ хуулийн 12.1.5-д заасан аргачлалын дагуу хийнэ.

51 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ

51.1.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх аргачлал дараах агуулгыг хамаарна:

51.1.1.хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах;

51.1.2.хууль тогтоомжийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг байдлыг тодорхойлох;

51.1.3.зохистой, үр дүнтэй хэрэгжих, хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох.

51.2.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг энэ хуулийн 12.1.6-д заасан аргачлалын дагуу хийнэ.

52 дугаар зүйл.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнг хэлэлцэх

52.1.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнг Улсын Их Хурал, Засгийн газар жилд нэг удаа тогтмол хэлэлцэж хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хууль тогтоомжид зохих нэмэлт, өөрчлөлт оруулах, хууль тогтоомжийг хооронд нь уялдуулах, хууль тогтоомжийг системчлэн кодификаци хийх, шинээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.



52.2.Улсын Их Хурал хууль тогтоомжийн төслийг хэлэлцэн батлахдаа тухайн хууль тогтоомжийн ач холбогдол, зохицуулалтын онцлогийг харгалзан шаардлагатай бол уг хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг танилцуулах хугацаатай үүргийг Засгийн газарт өгч болно.

**АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ
БУСАД ЗҮЙЛ**

53 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

53.1.Энэ хуулийг 2016 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 05 дугаар
сарын 29-ний өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.3.1, 19.3.4 дэх заалтын “төслийн” гэсний дараа “үзэл баримтлалын” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“18.4.Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх эсэх асуудлаар хэлэлцүүлэг явуулах үед гишүүд хууль санаачлагчаас төслийн үзэл баримтлалын талаар асуулт асууж, үг хэлж болох бөгөөд хэлэлцэх эсэх асуудлаар цөөнх болсон гишүүн нэгдсэн хуралдаанд үг хэлэх хүсэлтээ Байнгын хорооны санал, дүгнэлтэд тусгуулж болно.”



3 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.2 дахь заалт, 18 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 18.3 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн гарчиг, мөн зүйлийн 19.3.5 дахь заалтын “төслийг” гэснийг “төслийн үзэл баримтлалыг” гэж, 53 дугаар зүйлийн 53.10 дахь хэсгийн ““Төрийн мэдээлэл” эмхтгэлд” гэснийг ““Хууль тогтоомжийн эмхэтгэл”-д” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Хууль тогтоомжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 05 дугаар
сарын 29-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5, 43.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“43.5.“Хууль тогтоомжийн эмхэтгэл”-д хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг бүрэн эхээр нь нийтэлнэ.

43.6.“Хууль тогтоомжийн эмхэтгэл”-ийг хэвлэн нийтлэх ажлыг Тамгын газар хариуцна.”

2 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.4 дэх хэсгийн ““Төрийн мэдээлэл” эмхтгэлд” гэснийг ““Хууль тогтоомжийн эмхэтгэл”-д” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Хууль тогтоомжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 05 дугаар
сарын 29-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрийн мэдээлэл” эмхтгэлд албан ёсоор нийтлэхээс гадна” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Хууль тогтоомжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 05 дугаар
сарын 29-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийн “Төрийн мэдээлэл” эмхтгэлд” гэснийг “Хууль тогтоомжийн эмхэтгэл”-д гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хууль тогтоомжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 05 дугаар
сарын 29-ний өдөр

Улаанбаатар
хот

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “талууд болон “Төрийн мэдээлэл” сэтгүүлд” гэснийг “талуудад” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Хууль тогтоомжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 05 дугаар
сарын 29-ний өдөр

Улаанбаатар
хот

АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн ““Төрийн мэдээлэл” эмхтгэлд хэвлэн нийтлэх ба” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хууль тогтоомжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 05 дугаар
сарын 29-ний өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БУСАД ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, ӨРГӨН МЭДҮҮЛЭХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2001 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр баталсан Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хууль тогтоомжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 05 дугаар
сарын 29-ний өдөр

Улаанбаатар
хот

ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСЭГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хууль тогтоомжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 05 дугаар
сарын 29-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСЭГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцугай.



2 дугаар зүйл.Энэ хуулийг Хууль тогтоомжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 06 дугаар
сарын 11-ний өдөр

Улаанбаатар
хот

АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэг:

“6.5.Аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч харьяалах нутаг дэвсгэртээ согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг тогтооно.”

2/7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсэг:

“7.9.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авахыг хориглоно.”

3/13 дугаар зүйлийн 13.2-13.4 дэх хэсэг:

“13.2.Бүх нийтийн ерөнхий боловсролын агуулгад согтууруулах ундааны хор уршиг, хэрэглээний эсрэг эзэмшвэл зохих мэдлэгийг заавал тусгана.

13.3.Аж ахуйн нэгж, байгууллага нь байгууллагынхаа дотоодод болон үйл ажиллагаа явуулж байгаа хүрээндээ архидан согтуурч байгаа шалтгаан нөхцөлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авч, ажилтнууддаа архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах үүрэгтэй.

13.4.Архидан согтуурахтай тэмцэх, согтууруулах ундааны хор уршиг, хэрэглээний эсрэг үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагыг төрийн бодлогоор дэмжинэ.”

**4/13² дугаар зүйлийн 13².6.6 дахь заалт:**

“13².6.6.согтуугаар үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих.”

2 дугаар зүйл.Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.3 дахь заалтын “6.1,” гэсний дараа “6.5,” гэж, 16.3.4 дэх заалтын “7.6,” гэсний дараа “7.9,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг:

“4.3.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журмыг харьяалах нутаг дэвсгэрийн иргэдийн саналыг авсны үндсэн дээр батална. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоходоо аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан журмын дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсэд тухайн чөлөөт бүсийн захирагч олгоно.”

2/13² дугаар зүйлийн 13².6.2 дахь заалт:

“13².6.2.согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг судлах, архины хэрэглээ, түүнээс үүссэн сөрөг үр дагаврыг бууруулах, урьдчилан сэргийлэх, түүнд хяналт тавих үйл ажиллагааг дэмжих;”

3/13² дугаар зүйлийн 13².6.5 дахь заалт:

“13².6.5.архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэнийг дэмжих;”

4 дүгээр зүйл.Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5 дахь заалтын “7.7, 7.8-д” гэснийг “6.5, 7.7-д” гэж, 16.1.9 дэх заалтын “7.5-д” гэснийг “7.5, 7.9-д” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 13².6.4 дэх заалтын “эрүүл мэнд, нийгмийн халамж” гэснийг хассугай.

6 дугаар зүйл.Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 06 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9¹ дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9^{1.8}, 9^{1.9} дэх хэсэг нэмсүгэй:

“9^{1.8}. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Төсвийн тогтворжуулалтын сангийн хөрөнгийг хүүгийн түвшин нь арилжааны банкны тухайн жилийн хадгаламжийн хүүгийн түвшнээс багагүй байх санхүүгийн хэрэгсэлд байршуулна.

9^{1.9}. Энэ хуулийн 9^{1.7}, 9^{1.8} дахь хэсгийн хэрэгжилтийг Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгаж Улсын Их Хуралд танилцуулна.”

2 дугаар зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9¹ дүгээр зүйлийн 9^{1.6} дахь хэсгийн “Монголбанкн дахь төрийн сангийн” гэснийг “Төрийн сангийн нэгдсэн дансны” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9¹ дүгээр зүйлийн 9^{1.7} дахь хэсгийн “, Монголбанк хооронд байгуулсан гэрээний үндсэн дээр Монголбанк” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2015 оны 6 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 06 дугаар
сарын 19-ний өдөр

Улаанбаатар
хот

ШҮҮХ БАЙГУУЛАХ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

1 дүгээр зүйл. Давж заалдах шатны шүүхийг байгуулж, тэдгээрийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг доор дурдсанаар тогтооно:

№	Шүүхийн нэр	Байрших газрын нэр	Нутаг дэвсгэрийн харьяалал
Нэг.Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх			
1	Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймаг	Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
2	Говьсүмбэр, Дорноговь аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Говьсүмбэр, Дорноговь аймаг	Говьсүмбэр, Дорноговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
3	Өмнөговь, Дундговь, Төв аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Өмнөговь, Дундговь, Төв аймаг	Өмнөговь, Дундговь, Төв аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
4	Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймаг	Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
5	Говь-Алтай, Завхан аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Говь-Алтай, Завхан аймаг	Говь-Алтай, Завхан аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
6	Баян-Өлгий, Увс, Ховд аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Баян-Өлгий, Увс, Ховд аймаг	Баян-Өлгий, Увс, Ховд аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
7	Булган, Орхон, Хөвсгөл аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Булган, Орхон, Хөвсгөл аймаг	Булган, Орхон, Хөвсгөл аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
8	Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Дархан-Уул, Сэлэнгэ аймаг	Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
9	Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж

Хоёр.Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх

1	Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймаг	Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
2	Говьсүмбэр, Дорноговь аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Говьсүмбэр, Дорноговь аймаг	Говьсүмбэр, Дорноговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
3	Өмнөговь, Дундговь, Төв аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Өмнөговь, Дундговь, Төв аймаг	Өмнөговь, Дундговь, Төв аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
4	Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймаг	Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
5	Говь-Алтай, Завхан аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Говь-Алтай, Завхан аймаг	Говь-Алтай, Завхан аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
6	Баян-Өлгий, Увс, Ховд аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Баян-Өлгий, Увс, Ховд аймаг	Баян-Өлгий, Увс, Ховд аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
7	Булган, Орхон, Хөвсгөл аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Булган, Орхон, Хөвсгөл аймаг	Булган, Орхон, Хөвсгөл аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
8	Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Дархан-Уул, Сэлэнгэ аймаг	Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
9	Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
Гурав.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх			
1	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх	Улаанбаатар хот	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж

2 дугаар зүйл. Анхан шатны шүүхийн байршил, тэдгээрийн нутаг дэвсгэрийн харьяаллыг доор дурдсанаар тогтооно:

	Шүүхийн нэр	Байрших газрын нэр	Нутаг дэвсгэрийн харьяалал
Нэг. Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх			
1	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг
2	Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүрэг
3	Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Багануур дүүрэг
4	Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Налайх, Багахангай дүүрэг
Хоёр. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх			
1	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг
2	Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүрэг
3	Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Багануур дүүрэг
4	Багахангай, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн Налайх, Багахангай дүүрэг

Гурав.Захиргааны хэргийн анхан шатны шүүх

	Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Архангай аймаг	Архангай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
1	Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Архангай аймаг	Архангай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
2	Баян-Өлгий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Баян-Өлгий аймаг	Баян-Өлгий аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
3	Баянхонгор аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Баянхонгор аймаг	Баянхонгор аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
4	Булган аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Булган аймаг	Булган аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
5	Говь-Алтай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Говь-Алтай аймаг	Говь-Алтай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
6	Говьсүмбэр аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Говьсүмбэр аймаг	Говьсүмбэр аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
7	Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Дархан-Уул аймаг	Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
8	Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Дорноговь аймаг	Дорноговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
9	Дорнод аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Дорнод аймаг	Дорнод аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
10	Дундговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Дундговь аймаг	Дундговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
11	Завхан аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Завхан аймаг	Завхан аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
12	Орхон аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Орхон аймаг	Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж



13	Өмнөговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Өмнөговь аймаг	Өмнөговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
14	Өвөрхангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Өвөрхангай аймаг	Өвөрхангай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
15	Сүхбаатар аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Сүхбаатар аймаг	Сүхбаатар аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
16	Сэлэнгэ аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Сэлэнгэ аймаг	Сэлэнгэ аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
17	Төв аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Төв аймаг	Төв аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
18	Увс аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Увс аймаг	Увс аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
19	Ховд аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Ховд аймаг	Ховд аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
20	Хөвсгөл аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Хөвсгөл аймаг	Хөвсгөл аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
21	Хэнтий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Хэнтий аймаг	Хэнтий аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
22	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх	Улаанбаатар хот	Нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
Дөрөв.Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх			
1	Архангай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	Архангай аймаг	Архангай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж

2	Баян-Өлгий аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	Баян-Өлгий аймаг	Баян-Өлгий аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
3	Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	Баянхонгор аймаг	Баянхонгор аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
4	Булган аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	Булган аймаг	Булган аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
5	Говь-Алтай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	Говь-Алтай аймаг	Говь-Алтай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
6	Говьсүмбэр аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	Говьсүмбэр аймаг	Говьсүмбэр аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
7	Дархан-Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	Дархан-Уул аймаг	Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
8	Дорноговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	Дорноговь аймаг	Дорноговь аймгийн Алтанширээ, Айраг, Даланжаргалан, Дэлгэрэх, Сайхандулаан, Мандах, Иххэт, Хөвсгөл, Хатанбулаг, Сайншанд сумд
9	Дорнод аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	Дорнод аймаг	Дорнод аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
10	Дундговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	Дундговь аймаг	Дундговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
11	Завхан аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	Завхан аймаг	Завхан аймгийн Улиастай, Алдархаан, Дөрвөлжин, Завхан-Мандал, Идэр, Отгон, Ургамал, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Цэцэн-Уул, Сантмаргац, Сонгино, Шилүүстэй, Яруу, Эрдэнэхайрхан сумд



12	Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	Орхон аймаг	Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
13	Өмнөговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	Өмнөговь аймаг	Өмнөговь аймгийн Баяндалай, Булган, Гурвантэс, Даланзадгад, Мандал-Овоо, Номгон, Ноён, Сэврэй, Ханхонгор, Хүрмэн, Цогт-Овоо сумд
14	Өвөрхангай аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	Өвөрхангай аймаг	Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан, Богд, Уянга, Тарагт, Гучин-Ус, Зүүнбаян-Улаан, Нарийн тээл, Хайрхандулаан, Сант, Төгрөг, Баянгол, Арвайхээр сумд
15	Сүхбаатар аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	Сүхбаатар аймаг	Сүхбаатар аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
16	Сэлэнгэ аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	Сэлэнгэ аймаг	Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Зүүнбүрэн, Ерөө, Түшиг, Шаамар, Хүдэр, Жавхланта, Цагааннуур, Хушаат, Сүхбаатар сумд
17	Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	Төв аймаг	Төв аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
18	Увс аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	Увс аймаг	Увс аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
19	Ховд аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	Ховд аймаг	Ховд аймгийн Дөргөн, Буянт, Дарви, Дуут, Жаргалант, Зэрэг, Манхан, Мянгад, Мөнххайрхан, Чандмань, Эрдэнэбүрэн, Ховд сумд

20	Хөвсгөл аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	Хөвсгөл аймаг	Хөвсгөл аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
21	Хэнтий аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	Хэнтий аймаг	Хэнтий аймгийн Батноров, Батширээт, Баян-Адарга, Баян-Овоо, Баянхутаг, Биндэр, Дадал, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Мөрөн, Норовлин, Өмнөдэлгэр, Хэрлэн Цэнхэрмандал сумд
Тав.Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх			
1	Архангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Архангай аймаг	Архангай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
2	Баян-Өлгий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Баян-Өлгий аймаг	Баян-Өлгий аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
3	Баянхонгор аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Баянхонгор аймаг	Баянхонгор аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
4	Булган аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Булган аймаг	Булган аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
5	Говь-Алтай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Говь-Алтай аймаг	Говь-Алтай аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
6	Говьсүмбэр аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Говьсүмбэр аймаг	Говьсүмбэр аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
7	Дархан-Уул аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Дархан-Уул аймаг	Дархан-Уул аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж

8	Дорноговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Дорноговь аймаг	Дорноговь аймгийн Алтанширээ, Айраг, Даланжаргалан, Дэлгэрэх, Сайхандулаан, Мандах, Иххэт, Хөвсгөл, Хатанбулаг, Сайншанд сумд
9	Дорнод аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Дорнод аймаг	Дорнод аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
10	Дундговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Дундговь аймаг	Дундговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
11	Завхан аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Завхан аймаг	Завхан аймгийн Улиастай, Алдархаан, Дөрвөлжин, Завхан-Мандал, Идэр, Отгон, Ургамал, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Цэцэн-Уул, Сантмаргац, Сонгино, Шилүүстэй, Яруу, Эрдэнэхайрхан сумд
12	Орхон аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Орхон аймаг	Орхон аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
13	Өмнөговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Өмнөговь аймаг	Өмнөговь аймгийн Баяндалай, Булган, Гурвантэс, Даланзадгад, Мандал-Овоо, Номгон, Ноён, Сэврэй, Ханхонгор, Хүрмэн, Цогт-Овоо сумд
14	Өвөрхангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Өвөрхангай аймаг	Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан, Богд, Уянга, Тарагт, Гучин-Ус, Зүүнбаян-Улаан, Нарийн тээл, Хайрхандулаан, Сант, Төгрөг, Баянгол, Арвайхээр сумд

15	Сүхбаатар аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Сүхбаатар аймаг	Сүхбаатар аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
16	Сэлэнгэ аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Сэлэнгэ аймаг	Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Зүүнбүрэн, Ерөө, Түшиг, Шаамар, Хүдэр, Жавхлант, Цагааннуур, Хушаат, Сүхбаатар сумд
17	Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Төв аймаг	Төв аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
18	Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Увс аймаг	Увс аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
19	Ховд аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Ховд аймаг	Ховд аймгийн Дөргөн, Буянт, Дарви, Дуут, Жаргалант, Зэрэг, Манхан, Мянгад, Мөнххайрхан, Чандмань, Эрдэнэбүрэн, Ховд сумд
20	Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Хөвсгөл аймаг	Хөвсгөл аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж
21	Хэнтий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Хэнтий аймаг	Хэнтий аймгийн Батноров, Батширээт, Баян-Адарга, Баян-Овоо, Баянхутаг, Биндэр, Дадал, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Мөрөн, Норовлин, Өмнөдэлгэр, Хэрлэн Цэнхэрмандал сумд



Зургаа.Сум дундын шүүх			
	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх	Дорноговь аймаг, Замын-Үүд сум	Дорноговь аймгийн Улаанбадрах, Эрдэнэ, Өргөн, Замын-Үүд сумд
1	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх	Дорноговь аймаг, Замын-Үүд сум	Дорноговь аймгийн Улаанбадрах, Эрдэнэ, Өргөн, Замын-Үүд сумд
2	Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх	Завхан аймаг, Тосонцэнгэл сум	Завхан аймгийн Тэс, Баянтэс, Баянхайрхан, Асгат, Түдэвтэй, Нөмрөг, Тэлмэн, Их-Уул, Тосонцэнгэл сумд
3	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүх	Өмнөговь аймаг, Ханбогд сум	Өмнөговь аймгийн Баян-Овоо, Манлай, Цогтцэций, Ханбогд сумд
4	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүх	Өвөрхангай аймаг, Хархорин сум	Өвөрхангай аймгийн Хархорин, Хужирт, Бат-Өлзий, Есөнзүйл, Өлзийт, Бүрд, Баян-Өндөр сумд
5	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүх	Сэлэнгэ аймаг, Мандал сум	Сэлэнгэ аймгийн Мандал, Баянгол сумд
6	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүх	Сэлэнгэ аймаг, Сайхан сум	Сэлэнгэ аймгийн Орхон, Орхонтуул, Баруунбүрэн, Сант, Сайхан сумд
7	Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүх	Ховд аймаг, Булган сум	Ховд аймгийн Булган, Алтай, Үенч, Цэцэг, Мөст сумд
8	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүх	Хэнтий аймаг, Бор-Өндөр сум	Хэнтий аймгийн Галшар, Баянмөнх, Дархан, Бор-Өндөр сумд



3 дугаар зүйл. Энэ хууль хүчин төгөлдөр болмогц анхан болон давж заалдах шатны шүүхэд хянан хэлэлцэгдэж байгаа хэрэг, маргааныг энэ хуульд заасан нутаг дэвсгэрийн харьяаллын шүүхэд шилжүүлнэ.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2015 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 06 дугаар
сарын 19-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.1.5, 22.1.6 дахь заалт нэмсүгэй:

“22.1.5.сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх;
22.1.6.сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх.”

2 дугаар зүйл. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсэг:

“6.7.Бүх шатны шүүхийн шүүгчийн орон тоо, цалингийн хэмжээг Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг харгалзан Улсын Их Хурал тогтооно.”

2/19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэг:

“19.2.Давж заалдах шатны шүүх нь хэргийн оролцогчийн хүсэлтийг харгалзан тухайн шүүхийн байрших газарт шүүх хуралдааныг явуулж болох бөгөөд шүүх хуралдааны бэлтгэл хангах, шүүгч томилолтоор ажиллах нийтлэг журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална.”

3 дугаар зүйл. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8 дахь хэсгийн “(дугаар)” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.



5 дугаар зүйл. Энэ хуулийг Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 06 дугаар
сарын 19-ний өдөр

Улаанбаатар
хот

**ШҮҮХ БАЙГУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 2013 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр баталсан Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2015 оны 06 дугаар сарын 19-ний өдөр баталсан Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 06 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 53

Улаанбаатар
хот

**Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар
баримтлах бодлого батлах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого” /2015-2030/-ыг хавсралтаар баталсугай.

2.“Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-ыг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай:

1/“Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-ын зорилго, зарчимд нийцүүлэн холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;



2/“Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-д тусгасан зорилго, чиглэлийг Монгол Улсын жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, нийгмийн даатгалын сангийн болон улсын төсөвт тусгах, арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх.

3.“Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо /Д.Батцогт/-нд үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 38 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

Монгол Улсын Их Хурлын 2015 оны
53 дугаар тогтоолын хавсралт

**ТӨРӨӨС ТЭТГЭВРИЙН ШИНЭЧЛЭЛИЙН
ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО
/2015-2030/**

**Нэг.Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар
баримтлах бодлогын зорилго**

1.1.Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын зорилго нь хүн амын насны бүтцийн өөрчлөлт, дундаж наслалтын өсөлтөөс үүдэлтэйгээр зайлшгүй өсөн нэмэгдэх тэтгэврийн зардлыг төр, иргэн, ажил олгогч санхүүгийн чадавхаа үндэслэн хамтран хариуцаж, ахмад настны амьжиргаанд хүрэлцэхүйц зохистой хэмжээний тэтгэвэр олгох тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

1.2.Тэтгэврийн шинэчлэлийн бодлого нь тэтгэврийн даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлж, малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчид зориулсан тусгай хөтөлбөрийг бий болгож, тэтгэврийн тогтолцоонд хувийн хэвшлийн оролцоог сайн дурын нэмэлт даатгалын хэлбэрээр дэмжин, ахмад настан олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байх нөхцөлийг бүрдүүлж, даатгуулагчийг илүү олон жил хөдөлмөрлөж, тасралтгүй шимтгэл төлөхийг урамшуулна.



Хоёр.Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын зарчим

2.1.Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

2.1.1.Монгол Улсын ахмад настан бүр орлогын наад захын баталгаат тэтгэврээр хангагдах;

2.1.2.иргэн бүр хөдөлмөрийн чадвартай үедээ тэтгэврийн даатгалд хамрагдаж, өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрхтэй байх;

2.1.3.өндөр насны тэтгэврийн хэмжээ нь даатгуулагчийн авч байсан цалин хөлс, төлсөн шимтгэлийн хэмжээ, хугацаатай уялдаатай байх;

2.1.4.эрэгтэй, эмэгтэй даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтоолгох насны доод хязгаар ижил байх;

2.1.5.тэтгэврийн даатгалын сангийн зардлыг төр, иргэн, ажил олгогч хамтран хариуцах;

2.1.6.тэтгэврийн даатгалын сангийн орлого, зарлагыг тэнцвэржүүлж, сангийн алдагдлыг дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас хэтрүүлэхгүй байх;

2.1.7.хөдөлмөрийн бүтээмж өндөртэй даатгуулагчийг нэмэлт хуримтлал, хадгаламж үүсгэх замаар өндөр насны тэтгэвэр тогтоолгох үед санхүүгийн олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой болох нөхцөлийг хангаж, орлогын баталгааг нь нэмэгдүүлэх;

2.1.8.иргэний насан туршдаа суралцах, хөгжих нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй хөдөлмөрлөхийг дэмжин ахимаг насны иргэнд тохирсон ажлын байр бий болгохыг урамшуулах.

Гурав.Тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын чиглэл

3.1.Тэтгэврийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1.хөдөлмөрийн гэрээ, түүнтэй адилтгах бусад гэрээгээр ажиллаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос ажилтан, төрийн албан хаагчид тэтгэврийн даатгалд заавал шимтгэл төлж даатгуулах;

3.1.2.малчин, хувиараа болон албан бус хөдөлмөр эрхлэгчид зориулсан албан журмын тэтгэврийн даатгалын тусгай хөтөлбөр бий болгох;

3.1.3.тэтгэврийн даатгалын шимтгэл төлөх орлогын дээд хязгаараас давсан өндөр орлоготой даатгуулагч хувийн тэтгэврийн нэмэлт даатгалд сайн дурын үндсэн дээр даатгуулах нөхцөлийг бүрдүүлэх.

3.2.Олон давхаргат тэтгэврийн тогтолцоог бүрдүүлэх ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1.тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авах эрх үүсээгүй, амьжиргааны түвшин доогуур, орлогогүй ахмад настанд нийгмийн халамжийн тэтгэвэр олгох;

3.2.2.1960 оноос өмнө төрсөн иргэнд үйлчлэх эв санааны зарчимд үндэслэсэн тэтгэврийн даатгалын хуваарилалтын одоогийн тогтолцоог үргэлжлүүлэн мөрдөж, энэ тогтолцоонд параметрийн шинэчлэл хийх замаар тэтгэврийн сангийн санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах;

3.2.3.энэ заалтын 3.2.2-т заасан тогтолцооны хүрээнд олгох тэтгэврийн хэмжээг даатгуулагчийн авч байсан цалин хөлс, шимтгэл төлсөн хугацаанд үндэслэн тогтоох;

3.2.4.1960 оноос 1979 оны хооронд төрсөн даатгуулагчид цалин хөлс, шимтгэл төлсөн хугацаанд суурилсан тогтолцоо болон шимтгэлийн хийсвэр нэрийн дансны тогтолцоо /цаашид “нэрийн дансны тогтолцоо” гэх/-ны аль таатай нөхцөлөөр тэтгэврээ тогтоолгох сонголт олгох;

3.2.5.1979 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш төрсөн даатгуулагчийн тэтгэврийг нэрийн дансны тогтолцоонд үндэслэн тогтоох бөгөөд энэ тохиолдолд тэтгэврийн хэмжээг тэнцвэртэй байлгах зарчмыг баримтлан холбогдох хуульд тухайн үед нь өөрчлөлт оруулах;

3.2.6.даатгуулагч тэтгэвэр тогтоолгох насны хязгаарт хүрч, 10 ба түүнээс дээш жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бол өндөр насны тэтгэвэр авах эрхтэй байх;

3.2.7.1979 оноос өмнө төрсөн даатгуулагчийн өндөр насны тэтгэврийн хэмжээ нь ажилласан жил тутамд дундаж цалин хөлсний хоёр хувиас багагүй байхаар бодож тогтоох;

3.2.8.1979 оноос өмнө төрсөн даатгуулагчийн тэтгэвэр тогтооход баримтлах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг даатгуулагчийн таван жилийн цалин хөлсний дунджаар тодорхойлж байгааг 2020 оноос нэмэгдүүлж, 2025 он гэхэд даатгуулагчийн 10 жилийн цалин хөлсний дунджийг үндэслэн тодорхойлдог болох бөгөөд цаашид даатгуулагчийн шимтгэл төлсөн нийт хугацааны цалин хөлсний дунджийг үндэслэн тэтгэврийг тогтоох;



3.2.9.1960 ба 1979 оноос өмнө төрсөн даатгуулагч бүрд тэтгэврийн баталгаат хэмжээнээс багагүй тэтгэвэр тогтоож олгох бөгөөд тэтгэврийн баталгаат хэмжээг хүн амын амьжиргааны баталгаажих доод түвшин, улсын дундаж цалин хөлстэй уялдуулан Засгийн газар жил бүр тогтоох;

3.2.10.тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн ахмад настан бүрд суурь тэтгэвэр олгоно. Суурь тэтгэврийн хэмжээг хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулан Засгийн газраас жил бүр тогтоох бөгөөд суурь тэтгэврийн зардлыг тэтгэврийн даатгалын сан болон улсын төсвөөс хариуцан санхүүжүүлэх;

3.2.11.1979 оноос хойш төрсөн иргэнд үйлчлэх нэрийн дансны тогтолцоо нь шимтгэлийн орлогоороо тэтгэврийн зардлаа нөхдөг хуваарилалтын санхүүжилттэй байх;

3.2.12.нэрийн дансны тогтолцооноос олгох өндөр насны тэтгэврийн хэмжээг даатгуулагчийн төлсөн нийт шимтгэлийн хэмжээ, түүнд бодсон хийсвэр хүү, тэтгэвэр авах хугацааны дундаж илэрхийлэлд үндэслэн тогтоох;

3.2.13.нэрийн дансны тогтолцооноос олгох хөдөлмөрийн чадвар алдсаны болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр бодох аргачлалыг шинэчилж, тэтгэврийг даатгуулагчийн цалин хөлс болон шимтгэлтэй уялдаатай байхаар өөрчлөх;

3.2.14.2030 оноос тэтгэврийн даатгалын шимтгэлийг хэсэгчлэн хагас хуримтлалын тогтолцоонд, цаашид бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжүүлэх;

3.2.15.тэтгэврийн даатгалын шимтгэл тооцох, тэтгэвэр тогтооход баримтлах цалин хөлс, орлогын доод, дээд хэмжээг Засгийн газар тогтоох;

3.2.16.тэтгэврийн хэмжээг жил бүрийн үнийн өсөлт болон дундаж цалин хөлсний өсөлттэй уялдуулан нэмэгдүүлж, шаардагдах хөрөнгийг төсөвт тусгаж байх;

3.2.17.эдийн засаг, санхүү, хөрөнгийн зах зээлийн урьдчилсан нөхцөл хангагдсан тохиолдолд иргэн бүр сайн дурын үндсэн дээр хувийн тэтгэврийн нэмэлт даатгалд хувиараа болон ажил олгогчийн дэмжлэгтэйгээр даатгуулж, нэмэгдэл тэтгэвэр авах;

3.2.18.хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг хувийн хэвшлийн тэтгэврийн даатгалын сан ба уг сан бүхий хувийн хэвшлийн урт хугацааны даатгалын компани эрхлэн гүйцэтгэх бөгөөд эрх бүхий байгууллага эдгээр санд тусгай зөвшөөрөл олгож, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

3.2.19.даатгуулагчийн хувийн тэтгэврийн нэмэлт даатгалд төлөх шимтгэл, хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт үзүүлэх зэрэг асуудлыг хуулиар зохицуулах;



3.2.20.хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын тогтолцоо нь бүрэн хуримтлалын байх бөгөөд даатгуулагчийн тэтгэврийн хэмжээ түүний төлсөн шимтгэл, хөрөнгө оруулалтын өгөөжөөс хамаарах;

3.2.21.хувийн хэвшлийн тэтгэврийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын багцыг хянах, хөрөнгө оруулалтын эрсдлийг зохицуулах, хөрөнгө оруулалтын өгөөжийг даатгуулагчийн дансанд шилжүүлэх асуудлыг хуулиар зохицуулах;

3.2.22.цэргийн алба хаасны, нийгмийн халамжийн, 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэний тэтгэврийн зардал болон тэтгэврийн даатгалын сангийн алдагдлыг улсын төсвөөс санхүүжүүлэх.

3.3.Малчин, хувиараа болон албан бус хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.3.1.малчин, хувиараа болон албан бус хөдөлмөр эрхлэгчид зориулсан тэтгэврийн даатгалын тусгай сан байгуулж, шимтгэлийн хэмжээ, хугацаа, тэтгэврийн нас болон тэтгэвэр тогтоох, олгох харилцааг тусгай хуулиар зохицуулах;

3.3.2.малчин, хувиараа болон албан бус хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50-иас багагүй хувийг төрөөс хариуцах бөгөөд төрөөс тэтгэврийн даатгалын шимтгэлийг хариуцах хугацааг хуулиар зохицуулах;

3.3.3.тэтгэвэр бодох аргачлал нь энгийн, ойлгомжтой, даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацаанаас тэтгэврийн хэмжээ хамаарахаар байх;

3.3.4.нийгмийн даатгалын байгууллага нь тусгай санд шимтгэл цуглуулах үйл ажиллагааг эрхэлж, даатгуулагчийн өөрөө төлсөн шимтгэл болон төрөөс хариуцан төлсөн шимтгэлийг тухай бүр бүртгэж, даатгуулагчид мэдээлэх;

3.3.5.тусгай сангийн хуримтлагдсан хөрөнгийг өсгөн арвижуулах зорилгоор Засгийн газрын бонд, үнэт цаас, бусад эрсдэл багатай банк, санхүүгийн болон хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх.

3.4.Тэтгэврийн нас, тэтгэвэр тогтоох хөнгөлөлттэй нөхцөлийн тухайд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.4.1.хүн амын дундаж насжилттай уялдуулж, тэтгэвэр тогтоолгох насны доод хязгаарыг өөрчлөх асуудлыг судлах;

3.4.2.хүүхэд төрүүлж, хуульд заасан нас хүртэлх хугацаанд асарсан эхчүүдийн хүүхдээ асарсан хугацааг тэтгэврийн даатгалын шимтгэл төлж, ажилласнаар тооцон нийгмийн даатгалын сангаас олгох жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийн хугацааг нэмэгдүүлэх;



3.4.3.хөдөлмөрийн хэвийн бус нөхцөл /газрын доор болон хортой, халуун/-д ажиллагчдын хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоолгосон тэтгэврийн зардлыг тэтгэврийн ердийн нас хүртэлх хугацаанд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас хариуцах;

3.4.4.хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллагчдад хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэврийн ердийн наснаас өмнө тэтгэвэр тогтоох нас, ажилласан жилийн шалгуур болзлыг шинэчилж, хуулиар зохицуулах.

3.5.Тэтгэврийн даатгалын шимтгэлийн талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.5.1.ахмад настны тэтгэврийн үнэлэмжийг сайжруулах, ирээдүйн ахмад настны тэтгэврийн хувь хэмжээг бууруулахгүй байх үүднээс тэтгэврийн даатгалын сангийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үр ашигтай бодлого баримтлах;

3.5.2.малчин, хувиараа болон албан бус хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн хэмжээг хуулиар зохицуулах;

3.5.3.тэтгэврийн даатгалын шимтгэл ногдуулах, тэтгэвэр тооцох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын доод, дээд хязгаарыг улсын дундаж цалин хөлсний хэмжээтэй уялдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар жил бүр тогтоох;

3.5.4.хувийн тэтгэврийн нэмэлт даатгалд төлөх шимтгэлийн хувь хэмжээг ажил олгогч болон даатгуулагчийн харилцан тохиролцсон гэрээгээр зохицуулах.

3.6.Нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоог бэхжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.6.1.нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоо нь босоо удирдлагатай, улсын хэмжээний бүтэцтэй байх;

3.6.2.аж ахуйн нэгж, байгууллага даатгуулагчийн тооноос хамаарч орон тооны ба орон тооны бус нийгмийн даатгалын ажилтантай байх;

3.6.3.ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэлийг бүртгэх, баталгаажуулах, мэдээлэх, нууцлалыг хадгалах үйл ажиллагааг мэдээллийн дэвшилтэт технологи ашиглан гүйцэтгэх мэдээлэл, сургалтын төвийг нийгмийн даатгалын төв байгууллагын харьяанд шинэчлэн зохион байгуулах;

3.6.4.ажил олгогч, даатгуулагч хувийн тэтгэврийн нэмэлт даатгалд шимтгэл төлөх тохиолдолд шимтгэлээ нийгмийн даатгалын



байгууллагаар дамжуулан хувийн хэвшлийн тэтгэврийн даатгалын санд шилжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

3.6.5.нийгмийн даатгалын байгууллагын соёлыг хөгжүүлэх, удирдлагын нээлттэй, ил тод үйл ажиллагааг төлөвшүүлэн төсөв, санхүүгийн хариуцлага, дотоод хяналтыг сайжруулах;

3.6.6.нийгмийн даатгалын ажилтныг чадавхижуулах, давтан бэлтгэх, мэргэшүүлэх, тасралтгүй сургах сургалтын нэгдсэн тогтолцоотой болох;

3.6.7.хууль тогтоомжийн биелэлт, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагад хяналт тавих, нийгмийн даатгалын үйл ажиллагаа, тайлан мэдээллийг хэлэлцэж, зөвлөмж гаргах үүрэг бүхий Засгийн газар, даатгуулагч, ажил олгогчийг тэнцүү тоогоор төлөөлсөн зөвлөл байгуулж ажиллах.

Дөрөв.Тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга зам, үе шат, хүрэх үр дүн

4.1.Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг дараах арга замаар хэрэгжүүлнэ:

4.1.1.тэтгэврийн даатгалын хууль, эрх зүйн баримт бичиг, стратеги төлөвлөгөө, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлийг боловсруулж, хэрэгжүүлэхэд энэхүү бодлогыг эш үндэс болгож, шаардагдах хөрөнгийг улсын болон нийгмийн даатгалын сангийн төсөвт тусган хэрэгжүүлэх;

4.1.2.Засгийн газар, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийгмийн даатгалын төв байгууллага болон нийгмийн даатгалын харилцаанд оролцогч тал, ажил олгогч, байгууллага Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төлөвлөгөө батлан биелэлтийг зохион байгуулах;

4.1.3.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг тусган хэрэгжүүлж, хэрэгжилтийн үр дүнд хяналт шинжилгээ хийж ажиллах;

4.1.4.хүн амын насжилт, эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалан зайлшгүй тохиолдож болзошгүй тэтгэврийн даатгалын сангийн ирээдүйн алдагдал, нэрийн дансны тогтолцооноос хагас хуримтлалын тогтолцоонд шилжих тохиолдолд шаардагдах шилжилтийн зардлыг тус тус санхүүжүүлэх зорилгоор тэтгэврийн нөөц сан байгуулах.

4.2.Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ:



4.2.1.нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн төслийг шинэчлэн боловсруулж, Монгол Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн батлуулах /2015-2016 он/;

4.2.2.тэтгэврийн шинэчлэлийг хэрэгжүүлэх асуудлаар олон нийтэд чиглэсэн, мэдээлэл сурталчилгаа хийх замаар нийгэм дэх ойлголтыг сайжруулж, нийгмийн харилцан ойлголцол, зөвшилцөл, түншлэлийг бэхжүүлэх /2017-2020 он/;

4.2.3.Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах эхний үе шатны бодлогыг хэрэгжүүлэх /2017-2022 он/;

4.2.4.Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатны хэрэгжилтийн үр дүнг үнэлж, хоёр дахь шатны бодлогыг хэрэгжүүлэх /2023-2030 он/.

4.3.Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

4.3.1.даатгуулагч төлсөн шимтгэлтэйгээ уялдаатай тэтгэвэр авах олон давхаргат тэтгэврийн тогтолцоог бий болгох;

4.3.2.тэтгэврийн даатгалын сангийн алдагдлыг дунд болон урт хугацаанд бууруулснаар улсын төсвийн ачаалал багасч, иргэн, аж ахуйн нэгжид татварын дарамт үүсэхгүй байх;

4.3.3.тэтгэврийн даатгалын хамрах хүрээ нэмэгдэж, ахмад настан бүр наад захын орлогын баталгаагаар хангагдах;

4.3.4.хүн амын насжилттай уялдуулан тэтгэврийн шинэчлэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хууль эрх зүйн орчинг цогцоор нь шинэчлэх эрх зүйн үндэс бий болох;

4.3.5.малчин, хувиараа болон албан бус хөдөлмөр эрхлэгч тэтгэврийн даатгалд хамрагдаж, ирээдүйн нийгмийн баталгаа нь сайжрах;

4.3.6.өндөр орлоготой даатгуулагчид зориулсан хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын тогтолцоо бүрдэж, ахмад настан олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байх нөхцөл хангагдах;

4.3.7.тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны шинэчлэлийг эрчимжүүлж, 1960 оноос хойш төрсөн даатгуулагчийн тэтгэвэр буурахгүй байх;

4.3.8.тэтгэврийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийн технологи, удирдлага, байгууллагын бүтэц, чадавх бий болох;



4.3.9.тэтгэврийн шинэчлэлийн асуудлаар нийгэм дэх ойлголтыг сайжруулж, нийгмийн харилцан ойлголцол, зөвшилцөл, түншлэл бэхжих.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 06 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 55

Улаанбаатар
хот

Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 08 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтын “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, болон хууль зүйн чиглэлээр багшлах, судалгааны ажил эрхлэхийг;” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалтын “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох ... эрхтэй.”, Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан “... хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан ... иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно.” гэсэн заалтыг зөрчсөн байна.” гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 08 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2.Энэ тогтоолыг 2015 оны 06 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 06 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 56

Улаанбаатар
хот

Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 09 дүгээр дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэгт “Мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэрийг эс



зөвшөөрвөл шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгч захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд давж заалдах гомдол гаргах эрхтэй.” гэж заасны “гомдол гаргах” гэсний өмнөх “... давж заалдах ...” гэсэн хэсэг, 65.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг Мэргэжлийн хариуцлагын хороогоор дамжуулан гаргана.”, 65.3 дахь хэсгийн “Энэ хуулийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг Мэргэжлийн хариуцлагын хорооны ажлын албаны ажилтан хүлээн авч, маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгчид танилцуулах бөгөөд тэдгээрийн тайлбарыг авч хэргийн материалд хавсаргана.”, 65.4 дэх хэсгийн “Мэргэжлийн хариуцлагын хороо давж заалдах гомдолд маргааны оролцогч, тэдгээрийн төлөөлөгчөөс гаргасан тайлбарыг хавсарган маргаантай холбогдох бусад баримт сэлтийн хамт уг гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын гурав хоногийн дотор захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хүргүүлнэ.” гэсэн нь; Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт “Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн захиргааны хэрэг, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэнэ.” гэж заасны “... Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д заасан давж заалдах гомдлыг ...” гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “... шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно.” гэснийг тус тус зөрчсөн байна.” гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 09 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2.Энэ тогтоолыг 2015 оны 06 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 06 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 57

Улаанбаатар
хот

**“Гацууртын ордын төрийн эзэмшлийн
хувь тогтоох тухай” Улсын Их Хурлын
тогтоолын төсөл буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:



1.Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Гацууртын ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 05 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 58

Улаанбаатар
хот

**“Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний
тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга
хэмжээний тухай” тогтоолын зарим заалт
хүчингүй болсонд тооцох тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 1998 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 103 дугаар тогтоолын 2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

2.Энэ тогтоолыг Хууль тогтоомжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 06 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 59

Улаанбаатар
хот

Шүүгчийн орон тоо батлах тухай

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ батлагдсантай холбогдуулан давж заалдах шатны шүүхийн шүүгчийн орон



тоог 1 дүгээр хавсралтаар, анхан шатны шүүхийн шүүгчийн орон тоог 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Шүүгчийн орон тоо батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2013 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 12 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоолыг 2015 оны 06 дугаар сарын 19-ний өдөр баталсан Шүүх байгуулах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

Монгол Улсын Их Хурлын 2015 оны
59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

**ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН
ШҮҮГЧИЙН ОРОН ТОО**

Д/д	Шүүхийн нэр	Шүүгчийн орон тоо	
		Ерөнхий шүүгч	шүүгч
ИРГЭНИЙ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ОРОН ТОО			
1	Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	5
2	Говьсүмбэр, Дорноговь аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	4
3	Өмнөговь, Дундговь, Төв аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	5
4	Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	5
5	Говь-Алтай, Завхан аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	4
6	Баян-Өлгий, Увс, Ховд аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	5
7	Булган, Орхон, Хөвсгөл аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	6



8	Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	6
9	Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	1	15
	Нийт	9	55

**ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ
ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ОРОН ТОО**

1	Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	1	6
2	Говьсүмбэр, Дорноговь аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	1	5
3	Өмнөговь, Дундговь, Төв аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	1	6
4	Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	1	6
5	Говь-Алтай, Завхан аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	1	5
6	Баян-Өлгий, Увс, Ховд аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	1	6
7	Булган, Орхон, Хөвсгөл аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	1	7
8	Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	1	7
9	Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	1	15
	Нийт	9	63

**ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ
ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ОРОН ТОО**

1	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх	1	12
	Нийт	1	12



Монгол Улсын Их Хурлын 2015 оны
59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

**АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН
ОРОН ТОО**

Д/ д	Шүүхийн нэр	Шүүгчийн орон тоо	
		Ерөнхий шүүгч	шүүгч
ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ОРОН ТОО			
1	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	38
2	Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	38
3	Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	6
4	Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	1	6
	Нийт	4	88
ДҮҮРГИЙН ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ОРОН ТОО			
1	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	34
2	Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	34
3	Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	5
4	Багахангай, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	5
	Нийт	4	78
ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ОРОН ТОО			
1	Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3



2	Баян-Өлгий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
3	Баянхонгор аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
4	Булган аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
5	Говь-Алтай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
6	Говьсүмбэр аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
7	Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
8	Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
9	Дорнод аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
10	Дундговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
11	Завхан аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
12	Орхон аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
13	Өмнөговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
14	Өвөрхангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
15	Сүхбаатар аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
16	Сэлэнгэ аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
17	Төв аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
18	Увс аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
19	Ховд аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3



20	Хөвсгөл аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
21	Хэнтий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	3
22	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх	1	16
	Нийт	22	79
СУМ ДУНДЫН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ОРОН ТОО			
1	Архангай аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1	5
2	Баян-Өлгий аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1	5
3	Баянхонгор аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1	5
4	Булган аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1	5
5	Говь-Алтай аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1	4
6	Говьсүмбэр аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1	4
7	Дархан-Уул аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1	9
8	Дорноговь аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1	4
9	Дорнод аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1	7
10	Дундговь аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1	4
11	Завхан аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1	5
12	Орхон аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1	8



13	Өмнөговь аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1	4
14	Өвөрхангай аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1	5
15	Сүхбаатар аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1	5
16	Сэлэнгэ аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1	5
17	Төв аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1	6
18	Увс аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1	5
19	Ховд аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1	5
20	Хөвсгөл аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1	8
21	Хэнтий аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх	1	5
Нийт		21	113
СУМ ДУНДЫН ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ОРОН ТОО			
1	Архангай аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
2	Баян-Өлгий аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
3	Баянхонгор аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
4	Булган аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
5	Говь-Алтай аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
6	Говьсүмбэр аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3



7	Дархан-Уул аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	6
8	Дорноговь аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
9	Дорнод аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	4
10	Дундговь аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
11	Завхан аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
12	Орхон аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	5
13	Өмнөговь аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
14	Өвөрхангай аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
15	Сүхбаатар аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
16	Сэлэнгэ аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
17	Төв аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
18	Увс аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
19	Ховд аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
20	Хөвсгөл аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	5
21	Хэнтий аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	3
Нийт		21	71



СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ОРОН ТОО

1	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүх	1	5
2	Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь Сум дундын шүүх	1	4
3	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь Сум дундын шүүх	1	4
4	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Сум дундын шүүх	1	5
5	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын шүүх	1	4
6	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын шүүх	1	4
7	Ховд аймгийн Булган сум дахь Сум дундын шүүх	1	5
8	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь Сум дундын шүүх	1	4
Нийт		8	35

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 06 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 103

Улаанбаатар
хот

**Ц.Бямбажавыг албан тушаалаас
чөлөөлөх тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Цэрэндэжидийн Бямбажавыг Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 06 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 104

Улаанбаатар
хот

Д.Давааг албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 13 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Зэвсэгт хүчний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Дуламсүрэнгийн Давааг Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын албан тушаалд томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 06 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 108

Улаанбаатар
хот

Зарим хүмүүсийг анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 16, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Банзайн Манлайбаатарыг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 9 дүгээр шүүхийн шүүгчийн, Баасанжавын Зоригийг Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн шүүгчийн, Азуйсэдийн Мөнхзул, Гоошоохүүгийн Даваадорж нарыг Иргэний хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн шүүгчийн, Очирбатын Номуулинг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн, Сэнгээгийн Хишигбат, Лувсандоржийн Энхжаргал нарыг дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Доржсүрэнгийн Мөнгөнтуул, Батсүрэнгийн Хишигбатаар нарыг дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 2 дугаар



шүүхийн шүүгчийн, Ганбатын Ариунааг дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 3 дугаар шүүхийн шүүгчийн, Нямсүрэнгийн Баярсүрэнг дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 4 дүгээр шүүхийн шүүгчийн, Сарантуяагийн Ганбатыг Захиргааны хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Даваанямын Оюумаа, Нэрэндашийн Дуламсүрэн, Амгалангийн Насандэлгэр нарыг Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхийн шүүгчийн, Гэндэнгийн Алгирмааг Сум дундын 9 дүгээр шүүхийн шүүгчийн, Ванчинсүрэнгийн Амартүвшинг Сум дундын 27 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 06 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 109

Улаанбаатар
хот

Зарим хүмүүсийг шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өөр албан тушаалд томилогдсонтой холбогдуулан Гоошоохүүгийн Даваадоржийг дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Азуйсэдийн Мөнхзул, Очирбатын Номуулин нарыг дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн шүүгчийн, Баасанжавын Зоригийг дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Банзайн Манлайбаатарыг Сум дундын 7 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 5 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 183

Улаанбаатар
хот

Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2015 оны хэмжээг тогтоох тухай

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйл, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8.1.1, 8.1.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны сард төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг түүний сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4 хувь, үүнээс ажил олгогч 2 хувь, ажилтан 2 хувь байхаар тогтоосугай.

2. Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцдаг иргэн, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн суралцагч, малчин, ял эдэлж байгаа хоригдол болон Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.11-д заасан иргэний эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг тус тус 670 (зургаан зуун далан) төгрөгөөр, гадаадын иргэн, харьяалалгүй хүний эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 6 хувьтай тэнцүү байхаар тогтоосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2014 оны хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2013 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 423 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тогтоолыг 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

**ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

С.ЭРДЭНЭ



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2015 оны 06 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 05

Улаанбаатар
хот

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн холбогдох заалт Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн
хуралдааны танхим 13.30 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Наранчимэг даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн П.Очирбат, Н.Жанцан /илтгэгч/, Т.Лхагваа, Ш.Цогтоо, Д.Сугар, Д.Солонго, Д.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Д.Эрдэнэчимэг, Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нар оролцлоо.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт “Хяналтын шатны шүүхийн тогтоол эцсийнх байна. ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэж, Монгол Улсын Их Хурлын 2015 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 06 дугаар дүгнэлтийн тухай” 50 дугаар тогтоолын үндэслэлийг хянан хэлэлцэв.

Нэг. Иргэн Б.Баярсайхан, Д.Эрдэнэчимэг нар Үндсэн хуулийн цэцэд хандаж дараах агуулга бүхий мэдээлэл ирүүлжээ:

“Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд ... Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. ...” гэж заасан байна.

Улсын дээд шүүх хяналтын журмаар хэрэг, маргааныг шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэхдээ хуулийг Үндсэн хуулийн бус аргаар



тайлбарласан, буруу хэрэглэсэн, ноцтой зөрчсөн зэрэг алдаа гаргасан бол өөрийнхөө шийдвэрээ өөрөө засах боломжийг бий болгох, шүүх ямар ч тохиолдолд аливаа алдаагүй шийдвэр гаргах ёстой гэсэн үзэл баримтлалаар Үндсэн хуульд дээрх заалтыг тусгаж өгсөн билээ.

Үндсэн хуулийн энэ үзэл санааг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар нарийвчлан зохицуулахдаа аливаа хэрэг маргааныг хяналтын журмаар 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянаж шийдвэрлэх, ийнхүү хяналтын журмаар хэрэг шийдвэрлэхдээ шүүгч нар хууль зөрчсөн бол Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар дахин хэлэлцэж шийдвэрлэхээр тогтоосон билээ.

Тодруулбал, Улсын дээд шүүх өөрийн хуульд харшилсан шийдвэрийг өөрөө хүчингүй болгох Үндсэн хуулийн заалтыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 176¹ дугаар зүйлийн 176^{1.1} дэх хэсэгт “Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч энэ хуулийн 176.2-т заасан тогтоолыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хууль зөрчсөн үндэслэлээр Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргаж болно.”, мөн зүйлийн 176^{1.2} дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч гомдлыг үндэслэлтэй гэж үзвэл энэ хуулийн 174.1-д заасан хугацаанд дүгнэлт гаргаж, уг хэргийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцүүлнэ. ...” гэж нарийвчлан зохицуулж өгсөн юм.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1 дэх хэсэгт “Хяналтын журмаар гомдол гаргах, түүнийг шийдвэрлэхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172-178 дугаар зүйлд заасан журмыг баримтална.” гэж заасан учир захиргааны хэргийг хянан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн тогтоолд мөн адил журмаар гомдол гаргах боломжтой болно.

Монгол Улсын Их Хурал Монгол Улсын шүүхийн тухай хуулийг шинэчлэн батлахдаа шүүхийн тухай хууль дахь энэ зохицуулалтыг байхгүй болгож, ингэснээр ялангуяа Улсын дээд шүүх өөрийн хууль зөрчсөн шийдвэрийг өөрөө хүчингүй болгох эрх зүйн үндэслэлгүй болгож байна.

Хэдийгээр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 176¹ дугаар зүйлийн 176^{1.1}, 176^{1.2} дахь хэсэг, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1 дэх хэсэг нь хүчин төгөлдөр үйлчилсээр байгаа боловч Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч нь Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт “Хяналтын шатны шүүхийн тогтоол эцсийнх байна. ...” гэсэн тул аливаа гомдлыг хэлэлцэх нийт шүүгчдийн хуралдаан гэж байхгүй гэж тайлбарлаж байна.



Энэ нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 176¹ дугаар зүйлийн 176^{1.1}, 176^{1.2} дахь хэсгийг Үндсэн хуулийн бус замаар тайлбарлаж, Үндсэн хууль зөрчиж байгаа явдал мөн боловч, хамгийн гол нь Улсын Их Хурал “нийт шүүгчдийн хуралдаанаар гомдлыг хэлэлцэх” эрх зүйн үндэслэлийг байхгүй болгож байгаа нь Үндсэн хууль зөрчсөн ноцтой үйл явдал юм.

Иймд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт “Хяналтын шатны шүүхийн тогтоол эцсийнх байна. ...” гэж хуульчилсан нь Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд ... Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. ...” гэснийг зөрчсөн болохыг тогтоож өгнө үү.” гэжээ.

Хоёр. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“1. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж заасан. Энэ дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийг Улсын Их Хурлаас батлан гаргасан бөгөөд ингэхдээ шүүхийн зохион байгуулалт эрх зүйн байдлыг илүү тодорхой болгосон. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “Шүүхийн үндсэн тогтолцоо нь Улсын дээд шүүх /хяналтын шатны шүүх/, аймаг, нийслэлийн шүүх /давж заалдах шатны шүүх/, сум буюу сум дундын, дүүргийн шүүх /анхан шатны шүүх/-ээс бүрдэнэ.”, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Улсын дээд шүүх нь Монгол Улсын шүүхийн дээд байгууллага бөгөөд хяналтын шатны шүүх мөн.” гэж тус тус заасан. Анхан, давж заалдах шатны шүүхүүд дагнасан байдлаар зохион байгуулагдсан бөгөөд үүнтэй уялдаж нийцүүлэн Улсын дээд шүүх танхимын зохион байгуулалттай болсон. Иргэдийн мэдээлэлд дурдсан Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаан нь хэрэг, маргааныг дээрх 3 шатнаас гадна дөрөв дэх шатаар шийддэг байдлыг бий болгож байгаа юм.

2. Дэлхийн бусад улс орнуудад Дээд шүүхийн бүх шүүгчдийн хурал хийдэг тохиолдол байдаг бөгөөд энэ нь гагцхүү Дээд шүүх Үндсэн хуулийн шүүх хоёр нь нэг байгаа улс орнуудад ийм загвар байдаг бөгөөд манай улсад Дээд шүүх, Үндсэн хуулийн цэц хоёр тусдаа байх тул Улсын дээд шүүхэд хэрэг, маргааныг шийдвэрлэх 2 шат байх шаардлагагүй гэж үзсэн.



3. Монгол Улсын Их Хурлаас 2014 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулсан. Уг өөрчлөлтөөр хяналтын шатны шүүхийн тогтоолд үг, үсэг, тооны зэрэг техникийн шинжтэй алдаа гарсан бол танхимын шүүх бүрэлдэхүүн хуралдаж, залруулга хийнэ гэж заасан.

Дээр дурдсаныг үндэслэн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “Хяналтын шатны шүүхийн тогтоол эцсийнх байна. ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөрчөөгүй.” гэсэн байна.

Гурав. Үндсэн хуулийн цэц 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн дунд суудлын хуралдаанаараа энэхүү маргааныг хэлэлцэж 06 дугаар дүгнэлт гаргасан байна.

Уг дүгнэлтийн үндэслэл хэсэгт:

“1. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 176¹ дугаар зүйл, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 347 дугаар зүйлд хяналтын журмаар буюу Улсын дээд шүүхийн аль нэг танхимын 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хуралдаанаас гаргасан шийдвэр хуульд харшилсан гэж үзвэл Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид прокурор эсэргүүцэл бичих, иргэн гомдол гаргах журмыг нарийвчлан зохицуулсан зүйл, заалт хүчин төгөлдөр хэвээр байна.

Мөн Монгол Улсын Их Хурлаас 2014 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулсан. Уг нэмэлтээр хяналтын шатны шүүхийн тогтоолд үг, үсэг, тооны зэрэг техникийн шинжтэй алдаа гарсан бол танхимын шүүх бүрэлдэхүүн хуралдаж, залруулга хийж болох талаар зохицуулжээ.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд ... Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. ...” гэж зааснаар Улсын дээд шүүхийн шийдвэр эцсийнх байх ба хэрэв хуульд харшилсан шийдвэр гаргавал шийдвэрээ дахин хянаж Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгох боломж бий болгосон үзэл санааг илэрхийлсэн болно.

3. Монгол Улсын шүүхийн тухай хуульд Улсын дээд шүүх шийдвэрээ өөрөө хэрхэн хүчингүй болгох талаарх зохицуулалтыг тусгаагүй байна.



Үүний улмаас уг хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт “Хяналтын шатны шүүхийн тогтоол эцсийнх байна. Хяналтын шатны шүүхийн тогтоолд уг, үсэг, тооны зэрэг техникийн шинжтэй алдаа гарсан бол танхимын шүүх бүрэлдэхүүн хуралдаж, залруулга хийж болно.” гэж зааснаар Улсын дээд шүүхийн танхимын шийдвэрийг дахин хянаж хуульд харшилсан эсэхийг тогтоох, хүчингүй болгох боломжгүйд хүрч, Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “... Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно.” гэсэн заалт хэрэгжих үндэслэлгүй болсон байх ба улмаар процессын болон материаллаг хууль хоорондын зөрчлийг бий болгосон байна.

Иймд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт “Хяналтын шатны шүүхийн тогтоол эцсийнх байна. ...” гэж заасан нь Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх, Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгох тухай заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.” гэжээ.

Уг дүгнэлтийн дүгнэлт гаргах хэсэгт:

“1. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “Хяналтын шатны шүүхийн тогтоол эцсийнх байна. ...” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд ... Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. ...” гэснийг зөрчсөн байна.

2. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “Хяналтын шатны шүүхийн тогтоол эцсийнх байна. ...” гэсэн заалтыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авсан өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилсугай.” гэсэн байна.

Дөрөв. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дээр дурдсан дүгнэлтийг Монгол Улсын Их Хурал 2015 оны 5 дугаар сарын 21-ний өдөр хэлэлцээд “Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 06 дугаар дүгнэлтийн тухай” 50 дугаар тогтоол гаргасан байна. Уг тогтоолд:



“1. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “Хяналтын шатны шүүхийн тогтоол эцсийнх байна. ...” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд ... Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. ...” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 06 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.” гэжээ.

Тав. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“... Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.”, Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2/ дахь заалтад Монгол Улсын дээд шүүхийн бүрэн эрхэд “давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх;” гэж тус тус заасан. Энэ дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийг Улсын Их Хурлаас батлан гаргасан. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “Шүүхийн үндсэн тогтолцоо нь Улсын дээд шүүх /хяналтын шатны шүүх/, аймаг, нийслэлийн шүүх /давж заалдах шатны шүүх/, сум буюу сум дундын, дүүргийн шүүх /анхан шатны шүүх/-ээс бүрдэнэ.”, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Улсын дээд шүүх нь Монгол Улсын шүүхийн дээд байгууллага бөгөөд хяналтын шатны шүүх мөн.” гэж тус тус заасан. Анхан, давж заалдах шатны шүүхүүд дагнасан байдлаар зохион байгуулагдсан тул Улсын дээд шүүх танхимын зохион байгуулалттай болсон. Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаан нь хэрэг, маргааныг дээрх 3 шатнаас гадна дөрөв дэх шатаар шийддэг байдлыг бий болгож байгаа юм.

Өөрөөр хэлбэл, Улсын дээд шүүхийн танхим хяналтын журмаар хэрэг маргааныг хянан шийдвэрлэсэн байтал Үндсэн хууль болон Монгол Улсын шүүхийн тухай хуульд байхгүй дахин нэг шатлал “нийт шүүгчдийн хуралдаан буюу бүгд хурал” гэсэн зүйлээр нэмж үүсгэхээр болж байгаа нь Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2/ дахь заалтыг зөрчихөөр байна.

Ром, германы эрх зүйн тогтолцоо бүхий улс орнуудад дээд шүүхийн шийдвэрийг хянадаг ганцхан субъект нь Үндсэн хуулийн шүүх байдаг.

Дэлхийн бусад улс орнуудад Дээд шүүхийн бүх шүүгчдийн хурал хийдэг тохиолдол байдаг бөгөөд энэ нь гагцхүү Дээд шүүх Үндсэн хуулийн



шүүх хоёр нь нэг байгаа улс орнуудад ийм загвар байдаг бөгөөд манай улсад Дээд шүүх, Үндсэн хуулийн цэц хоёр тусдаа байх тул Улсын дээд шүүхэд хэрэг, маргааныг шийдвэрлэх 2 шат байх шаардлагагүй гэж үзсэн.” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт “Хяналтын шатны шүүхийн тогтоол эцсийнх байна. ...” гэж хуульчилсан нь Улсын дээд шүүх хуульд харшилсан шийдвэр гаргасан бол тухайн шийдвэрийг Улсын дээд шүүх өөрөө хянаж, хүчингүй болгох эрхийг хязгаарласан шинжтэй байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд ... Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. ...” гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 176¹ дугаар зүйл, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 347 дугаар зүйлд хяналтын журмаар буюу Улсын дээд шүүхийн аль нэг танхимын 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хуралдаанаас гаргасан шийдвэр хуульд харшилсан гэж үзвэл Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид прокурор эсэргүүцэл бичих, иргэн гомдол гаргах журмыг нарийвчлан зохицуулсан зүйл, заалт хүчин төгөлдөр хэвээр байгаа болохыг дурдах нь зүйтэй.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 06 дугаар дүгнэлт үндэслэлтэй байна.

4. Монгол Улсын Их Хурлын 2015 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 50 дугаар тогтоолд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 06 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй тухай үндэслэлээ заагаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон



**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС
ТОГТООХ НЬ:**

1. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “Хяналтын шатны шүүхийн тогтоол эцсийнх байна. ...” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд ... Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. ...” гэсэн заалтыг зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.

2. Монгол Улсын Их Хурлын 2015 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 06 дугаар дүгнэлтийн тухай” 50 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэхүү тогтоол гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ

Д.НАРАНЧИМЭГ

ГИШҮҮД

**П.ОЧИРБАТ
Н.ЖАНЦАН
Т.ЛХАГВАА
Ш.ЦОГТОО
Д.СУГАР
Д.СОЛОНГО
Д.ГАНЗОРИГ**

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 5.25

Индекс: 14003